

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.10.05

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид энэ сард 1 удаа хуралдаж 4 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

1.2020 оны 09-р сарын 21-ний өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит 19 дүгээр хуралдаанаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцээд орлогын гүйцэтгэлийг 78.249.299.820.66 төгрөгөөр, төсвийн зарлагын гүйцэтгэлийг 78.038.726.178.82 төгрөгөөр тус тус баталж аймгийн бүх шатны төсвийн эрх захирагчдад санхүү, төсвийн хууль тогтоомж, аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллахыг үүрэг болголоо.

2.Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн төсвийн орлого 8-р сарын байдлаар 911.5 сая төгрөгөөр тасарч (энэ нь 4 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл аж ахуйн нэгж байгууллагыг Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөнтэй холбоотойгоор үүссэн орлогын тасралт болно) цаашид орлого бүрэлдэхгүй байх нөхцөл байдал үүсч болзошгүй байгаа тул аймгийн нийт орлогоос 1093.7 сая төгрөгөөр бууруулах, Улсын төсөвт тодотголд аймагт олгох санхүүгийн дэмжлэг 319.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 401.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 851.1 сая төгрөгөөр тус тус буурсан.Иймд тусламжийн орлогын дүнг 1572.4 сая төгрөгөөр бууруулах, аймгийн төсвийн нийт орлого, зарлагыг 2666.1 сая төгрөгөөр тус тус бууруулан аймгийн 2020 оны төсвийг тодотголоо.

3.Бичил худалдаа ажил үйлчилгээ эрхлэгч хувь хүний албан татварын хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхэлж орлого олж байгаа хувь хүний орлогод сард ногдуулах албан татварын хувь хэмжээг дараах байдлаар тогтоолоо. Ингэхдээ албан татварын хувь хэмжээг бичил худалдаа, ажил үйлчилгээний төрлөөс хамааруулан тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1-25 хувь хүртэл байхаар тооцон тогтоолоо.

4.Авто зогсоолын үнэ тогтоох тухай асуудлыг хэлэлцээд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Баянханы 4 дүгээр багт баригдаж буй “Төрийн албан хаагчдын 120 айлын орон сууц”-ны нэг авто зогсоолын худалдах үнийг 12,0 сая төгрөгөөр тогтоолоо.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард 2 удаа хуралдан 11 асуудал хэлэлцэн дараах тогтоол баталлаа. Үүнд:

1.Эрүүл мэнд, соёл урлаг, хөдөө аж ахуйн салбарт идэвх зүтгэлтэй ажилласан зарим иргэдийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнав.

2.Аймгийн ИТХ-ын 19 дүгээр хуралдааныг 2020 оны 09-р сарын 21-ний өдөр хуралдуулахаар товыг тогтоов.

3.”Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн тухай аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн мэдээллийг хэлэлцээд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэв. Мөн төрийн архивын техник хэрэгслийн хүчин чадал, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх болон бусад үйл ажиллагааны зардалд зориулан архивын төлбөрт үйлчилгээний тухай жилийн орлогын 40 хувийг зарцуулах эрхийг тус архивт олголоо.

4.2020 онд ойгоос бэлтгэх модны хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн нутаг дэвсгэрээс 2020 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар бэлтгэх хэрэглээний болон түлээний модны нөөцөөс Ерөө суманд 3335 шоо метр модыг нэмэлтээр олгов.

5.Үндсэн хөрөнгө актлаж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

6.Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцэн зарим байгууллагын тээврийн хэрэгсэл, барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг тогтоов.

7.Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд Алтанбулаг сумын 1-р цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цэцэрлэгийн барилга, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг тус сумын 3-р цэцэрлэгт, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг Мандал, Баянгол сумын ЗДТГ-т тус тус шилжүүлэхийг зөвшөөрлөө.

8.Боловсролын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Шаамар сумын ЕБС-ийн зураг дизайн, технологийн багш Дашнямын Бямбасүрэнг “Монгол Улсын Гавьяат багш” цолоор, Эрүүл мэнд, төрийн үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан 1 иргэнийг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор, “Алтан гадас одон”-оор 3 иргэнийг, Худалдаа бэлтгэл, спортын салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж ирсэн зарим иргэдийг төрийн одон медалиар шагнуулахаар, Хүдэр сумын 1 дүгээр багийн иргэн Н.Эрдэнэхүүд Алдарт эхийн 1, 2 дугаар одон, одонгийн үнэмлэхийг нөхөн олгуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

9.Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Бурханы хайр” сүм, Буддын шашны “Төгс баясгалант номын хүрд” хийд, Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа Буддын шашны “Амарбаясгалант” хийд, Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн Зүүнхараа цуглаан”-ы үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилийн хугацаагаар сунгалаа.

10.Ковид-19 цар тахлын үед өвчлөлийн голомтод ажиллаж байгаа эрүүл мэндийн болон хил хамгаалах байгууллагын зарим алба хаагчдыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшуулав.

11.Нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагад удаа дараа сонгогдон томилогдож эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

Сэлэнгэ аймагт “Жендерийн мэдрэмжтэй бодлого ба төсөвлөлт” сэдэвт орон нутгийн төрийн албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулагдаж, сургалтад 17 сумын 160 албан хаагч хамрагдлаа.

Төрийн албаны зөвлөлөөс улс орон даяар нэгэн зэрэг онлайн хэлбэрээр зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл-ёс зүйн хандлага” сэдэвт төрийн байгуулагуудын ёс зүйн нэгдсэн зөвлөгөөнд 17 сум 6 тосгон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдыг ажлын байрнаас бүрэн хамруулж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Удирдлагын академи хамтран аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд, харъяа агентлагийн хүний нөөцийн ажилтнууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг хамруулсан “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох нь”, “Төрийн захиргааны байгууллагад сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж байгаа өнөөгийн байдал”, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй, сургалтын хөтөлбөрийн жишиг загвар”, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь”, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх” зэрэг сэдвүүдээр онол, дадлага ажил хосолсон 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески тэргүүтэй төлөөлөгчид Сэлэнгэ аймагт албан айлчлал хийлээ. Америкийн Нэгдсэн Улсын Цэргийн Инженерийн Корпусын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сумын Боргүвээ 5 дугаар багийн нутагт 50 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгыг хүлээлгэн өгөх, нээлтийн үйл ажиллагаа боллоо. Тус үйл ажиллагаанд Засгийн газрын гишүүн Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Засгийн газрын гишүүн Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нар оролцлоо.

Засгийн газрын гишүүн, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Засгийн газрын гишүүн, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн нар Сэлэнгэ аймагт ажиллаж, тус аймагт хэрэгжиж буй төрийн албан хаагчдад зориулсан хөнгөлөлттэй нөхцөлт 120 айлын орон сууцны төсөл хөтөлбөртэй танилцаж, цаашид уг хөтөлбөрийг бүх сумдад хэрэгжүүлж, иргэдээ инженерийн шугам сүлжээнд холбогдсон орчин үеийн орон сууцаар хангахаар төлөвлөж байгаагаа, Монгол Улсын хэмжээнд Сэлэнгэ аймгийн энэхүү туршлагыг нэвтрүүлэх хүсэлтээ аймгийн Засаг дарга Ш.Оргил уламжилж, Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар уг төслийн ажлыг онцгойлон сайшааж, цаашид үргэлжлүүлэн төрийн албан хаагчид болон хувийн хэвшлийнхэнд хүртээмжтэй болгоход дэмжиж ажиллана гэдгээ илэрхийлсэн.Мөн байгалийн үзэсгэлэнт “Сайханы хөтөл” орчимд үе шаттайгаар баригдахаар төлөвлөгдсөн ажлуудын зураг төсөв болон эхний ээлжинд хийгдэж эхэлсэн ажлуудтай танилцан тус төслийг үр дүнтэй болгох

чиглэлд заавар зөвлөгөө өгч, сайд өөрийн багцаас Сүхбаатар сумын үерийн далангийн зураг төсөв, Сүхбаатар сумын ерөнхий төлөвлөгөөний зураг төсвийн ажлуудыг шийдлээ.

Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын хамт аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга мэргэжилтнүүд, Сүхбаатар сумын төвийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай уулзаж, 1,2,4 дүгээр сургууль, Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцлаа.

COVID-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийн үед МОБИКОМ корпораци нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэгт 9.000.000 төгрөгийн тоног төхөөрөмжийг хандивлалаа.

Мандал сумын байгаль орчны хяналтын тасагт байнгын хяналтын цэгийг байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар худалдан авч хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газартай хамтран Төрийн үйлчилгээний нэгдсэн портал системийг аймгийн хэмжээнд 17 сумандаа нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 54 нэр төрлийн лавлагаа үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Сэлэнгэ аймагт аичлал хийж, газар тариалангийн бүс нутаг Сайхан, Цагааннуур сумын ургац хураалтын явц, үйл ажиллагаатай танилцлаа. Мөн Сайхан сумын Хөтөлийн “Цемент Шохой” ХК-ий үйл ажиллагаатай танилцаж, үйлдвэрийн зүгээс зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд тулгуурлан шохойн утааг багасгах, цемент шохойгоор хийж болох бүхий л түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилттой ажиллаж байгаагаа танилцууллаа.

Монгол Улсын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд "Улаанбаатар-Алтанбулаг" чиглэлийн ОУ-ын автозамаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км автозам барих талаар тусгагдсан бөгөөд замыг концессын гэрээгээр гүйцэтгүүлэхээр болсон. Уг айлчлалын үеэр Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур- Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын төслийн ажлын явцтай танилцсан. Автозамын ажлыг зураг төслийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргил тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхдүүдийн эцэг эхийн төлөөллийг хүлээн авч уулзан санал солилцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Сэлэнгэ аймагт ажиллаж, иргэдтэй уулзаж, 382 ээжид, “Алдарт эхийн одон”-г гардуулж, үүнээс Нэгдүгээр зэргийн одонг 38, Хоёрдугаар зэргийн одонг 344 ээжид тус тус хүртээлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Цэргийн штабын 2020 оны цэргийн сургалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020 оны А/244 тоот захирамжаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан Баянгол, Зүүнбүрэн, Мандал, Сант сумдын 30 иргэнд “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтыг Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 10 хоногийн хугацаатай

зохион байгуулсан. Мөн тусгай үүргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулж 30 бэлтгэл үүрэгтэнг хамруулан ажиллалаа.

**Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Тайлангийн хугацаанд Газрын даргын тушаал 10, албан бичиг 15 боловсруулан Онцгой байдлын ерөнхий газар, аж ахуй нэгж, байгууллагуудад хүргүүлж, ирсэн 24 албан бичгийг бүртгэл хяналтад авч, иргэд, албан хаагчдаас ирүүлсэн 9 өргөдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажилласан.

**Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдал хангах арга хэмжээний талаар:**

- Хүчтэй аадар бороо, нөөлөг салхинаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ боловсруулан Онцгой байдлын газрын цахим хуудсанд байршуулж, сумдад албан бичгээр зөвлөмж хүргэн ажилласан.
- COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ОХУ-аас Алтанбулаг боомтоор 96 иргэнийг татан авах ажиллагааг зохион байгуулан Дархан-Уул, Орхон аймагт тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулсан.
- 09-р сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд халдвартын тасагт 7, Мандал сум “Алсын өртөө” ХХК-ий тусгаарлан ажиглах байранд 10 нийт 17 иргэн, тусгаарлалтад байгаа бөгөөд Онцгой байдлын газрын алба хаагчид 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

Мөн Алтанбулаг шалган нэвтрүүлэх хилийн боомтоор ОХУ-аас орж ирж буй ачаа тээврийн хэрэгслийг цагдаагийн байгууллагатай хамтран Улаанбаатар хотын Гаалийн хяналтын талбайд хүргэх, Сүхбаатар сумын гаалын хяналтын 4 цэгт ачаа буулгахаар ирж буй Олон улсын 145 ачаа тээврийн хэрэгсэлд Цагдаа, Зооноз өвчин судлалын төвтэй хамтран хяналт тавин ариутгал халдваргүйтгэл хийн ажилласан.

Энэ хугацаанд хорио цээр хязгаарлалтын дэглэм зөрчсөн 1 иргэнд зөрчлийн тухай хуулийн 5.13.4 дэх хэсэгт заасны дагуу 100 нэжээр торгох арга хэмжээ авч 3 иргэнд зөрчлийн хэрэг нээн ажиллаж байна.

**Аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээлэл:** Тус сард аймгийн хэмжээнд 12 удаагийн дуудлага ирсэн. Үүнд:

- Объектын гал түймэр-5
- Үерийн дуудлага-1
- Гол нуурын усанд унаж осолдсон-3
- Аврах ажиллагааны-3 дуудлага тус тус ирсэн.

2020 оны 09 дүгээр сарын 10-ны 23 цаг 10 минутаас 20 минутын хугацаатай нөөлөг салхитай түр зуурын усархаг аадар бороо орж үргэлжлэн зүсэрсний улмаас үерийн аюулын шинжтэй 5 дуудлага ирсэн. Үүнд:

1. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ий 20 орчим метрийн урттай өндөр хүчдэлийн шугам дамжуулах хонгилд 30 см орчим үерийн ус тунасан. Урсгал ус ХХК-ий ус соруулах тусгай зориулалтын автомашинаар нийт 16 тонн буюу 45,2 м<sup>3</sup> ус соруулан гаргасан. Үерийн хор уршгийг арилгах ажиллагаанд ОБГ-аас 8 алба хаагч, 1 техник, “Урсгал Ус” ХХК-ны 2 ажилтан, 1 техник, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээний 6 ажилтан 1 техниктэйгээр хамтран ажилласан.

2. 12 жилийн 2 дугаар сургуулийн гадна фасад буюу сайтинк, ордог хаалганы дээд талын дээврийн модон болон төмөр хийц хууларч 50 орчим метр газар хийсч унасан.
3. Аймгийн эмэгтэйчүүдийн холбооны байрны дээврийн төмөр болон модонхийц хууларч унасан, мөн 2 давхарын гипсэн тааз борооны усанд нэвчин хууларч 2 давхартаа борооны ус орсон.
4. “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын Захиргааны барилгын дээврийн модон хийц хууларч унасан.
5. Сүхбаатар сум 2 дугаар баг Дулаан хувиарлах төвийн дээврийн төмөрболон модон хийц хүчтэй салхины улмаас хууларч унасан.
6. Олон улсын худалдааны төвийн баруун талд шинээр баригдсан түрээсийн 8 айлын орон сууцны халаалтын шугамд үерийн ус орж айлууд руу орох нөхцөл байдал үүссэн талаарх дуудлагын дагуу Гал түймэр унтраах аврах 36 дугаар ангийн 1 тасаг очиж усыг боож байсан блокон хашаанд нүх гарган үерийн усны голдирлыг өөрчлөн аюулгүй болгож ажилласан.

Бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх бэлтгэл бэлэн байдлын хангах чиглэлээр Дархан-Уул, Орхон аймгийн аймгийн Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0143 дугаар ангитай хамтран дараах арга хэмжээг зохион байгуулж, “Уснаас эрэн хайх аврах ажиллагааны сургалт”-д Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар хамтарсан 47 албан хаагч, “Өндөр уулнаас эрэн хайх аврах ажиллагааны сургалт”-д Сэлэнгэ, Дархан, Орхон, Хилийн 0243-р анги хамтарсан 54 албан хаагч нийт 101 албан хаагч, 5 нэгж техник хамрагдсан.

#### **Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:**

2020 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар 15 хуулийн этгээд, төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 6 иргэн, 17 хуулийн этгээд, урьдчилан сэргийлэх хяналтаар 168 хуулийн этгээд, 8 иргэн, тандалт судалгаар 3 иргэн, хяналт шинжилгээгээр 11 хуулийн этгээд, 2 иргэн, нийт 225 зөрчил дутагдлыг илрүүлж, 111 зөрчлийг арилгуулан, 211 хуулийн этгээд, 19 иргэнд 4.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, 1.200.000 төгрөгийн торгуулийг барагдуулан, шалгалтын явцад албан шаардлага 12/93 заалттай, 1/4 зөвлөмжийг үйлдэн биелэлтийг тооцон ажиллалаа.

Төлөвлөгөөт шалгалтыг Орхонтуул сумын Тохой-1 хэмээх газарт үйл ажиллагаа эрхэлж буй “Олз газар” ХХК-д хяналт шалгалт хийж шаардлагатай бичиг баримт байхгүй байсан тул Геологи уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагчтай хамтран үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоож, Цагааннуур сумын Засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу хяналт шалгалт хийгдэж байна. Сүхбаатар сумын 1 иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу шалгалт хийж Зөрчлийн тухай хуулиар 500 нэгжээр торгуулийн арга хэмжээ авч, Түшиг, Зүүнбүрэн суманд 2 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Баянгол, Мандал сумдын 10 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан улсын байцаагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцон, Мандал, Баянгол сумын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдаж буй 1 барилга, хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 2 шинэ барилга байгууламжид хянан баталгаажуулах

ажлыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан улсын комиссоор хүлээн авах шийдвэрийг гарган ажиллалаа.

Төлөвлөгөөт гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Цагааннуур сумын “Гацуурт хүнс” ХХК-д, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Баянгол, Мандал сумдын 8 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан, улсын байцаагчийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцон, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Шаамар сумын 1-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэхэд шизоафектив эмгэгийн холимог хэлбэртэй хүнийг хүүхдийн эмчээр авч ажиллуулсан, хоёр нүд сохрох оноштой хүнээр 24 цагийн жижүүрийн ажлыг хийлгэж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангаагүй ноцтой зөрчил илэрлээ. Илэрсэн зөрчлийг арилгуулах эрсдлийг бууруулах зорилгоор улсын байцаагчийн 1 зөвлөмжийг 6 заалттайгаар хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 32 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 02 дугаар албан даалгавар, Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/17 дугаар тушаал, тушаалын нэг, хоёрдугаар хавсралт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/96 тоот удирдамж, 01/2215 дугаар албан бичгийн дагуу 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, салбарын хууль тогтоомж тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, дүрэм, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, аймгийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор ерөнхий боловсролын 35 сургууль, сургуулийн сурагчдын 17 дотуур байр, сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллага, хүнсний бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч 28 байгууллага, нийт 123 байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийлээ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад ерөнхий боловсролын сургуульд 42, сургуулийн дотуур байранд 26, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 54, ханган нийлүүлэгч байгууллагатай холбоотой 35 зөрчил нийт 157 зөрчлийг илрүүлж, газар дээр нь 78 зөрчлийг арилгуулж, зөрчил дутагдлыг арилгуулах талаар улсын байцаагч нарын хамтарсан 46 заалттай 6 албан шаардлагыг хугацаатай өгч биелэлтийг тооцохоор шийдвэрлэж, 10 заалттай 2 зөвлөмжийг 123 байгууллага аж ахуйн нэгжид хүргэж ажилласан.

МХЕГ-ын 01/66 тоот удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар багт байрлалтай “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын Мал төхөөрөх газар, Цагааннуур сумын Цагаантолгойд байрлах “Гацуурт хүнс ХХК”-ий Мах боловсруулах үйлдвэр, Мандал сумын 3 дугаар багт байрлах “Мандал энерго” ОНӨААТҮГ-ын Мах бэлтгэх төвд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, МХЕГ-ын 01/96 дугаартай удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд МСҮТ-ийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, коронавируст халдварын цар тахлын үед авах хариу арга хэмжээний бэлэн байдал, хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдалд шинжилгээт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж ажиллалаа. МХЕГ-ын 01/05 тоот удирдамжийн дагуу МУ-ын Ерөнхий сайдын зоогонд хяналт тавьж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн сурагчид хоолны хордлого авсан байж болзошгүй гэх мэдээллийн дагуу тус сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Хяналт шалгалтын явцад мах нийлүүлдэг “Эко мандал хүнс” ХХК нь гарал үүсэлгүй, шинжилгээний бичиг нь хуурамч үхрийн махыг тус сургуульд нийлүүлж байсан нь тогтоогдож МУ-ын Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтын 1.1 дэх заалтыг үндэслэн 1500 нэгжийн шийтгэврийн арга хэмжээг хялбаршуулсан журмаар авч шийдвэрлэлээ. Мөн тус сургууль нь “Шинэ шүүдэр” ХХК-тай төмс хүнсний ногоо худалдан авах гэрээг 2018 оноос эхлэн байгуулж хамтран ажиллаж ирсэн. “Шинэ шүүдэр” ХХК нь ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхдээ гарал үүслийн бичиггүй, чанар аюулгүй байдлыг тодорхойлсон шинжилгээний бичиггүй нийлүүлдэг нь баримтаар нотлогдож байгаа нь “Ургамал хамгааллын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалтыг зөрчиж байна. Иймд “Зөрчлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.8.5 дахь заалтыг үндэслэн 500 нэгжийн шийтгэвэрийн арга хэмжээг хялбаршуулсан журмаар авч шийдвэрлэлээ.

Мандал сумын Ерөнхий боловсролын 3-р сургууль 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр “Шинэ шүүдэр” ХХК-иас 7 нэр төрлийн 123.5 кг төмс хүнсний ногоо худалдан авсан. Тухайн бүтээгдэхүүнүүд нь 2020 онд тариалагдсан шинэ ургац бөгөөд гарал үүсэл, шинжилгээний бичиггүй байсан тул 7 нэр төрлийн төмс, хүнсний ногооноос зохих журмын дагуу авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлуулахаар шинжилгээнд өгч ажиллахад шинжилгээний хариу сөрөг гарсан байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 8 дугаар багт байрлалтай “Сүхбаатар хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын мал төхөөрөх газраас үхрийн махны 4 дээж, Цагааннуур сумын Цагаантолгойд байрлах “Гацуурт хүнс” ХХК-ий мах боловсруулах үйлдвэрийн 50 үхрийн махны дээж, Мандал сумын Хэрх 4-р багт байрлах сүүний чиглэлийн фермерийн үйл ажиллагаа явуулдаг “Макс агро” ХХК-ий 30 үхрээс сүүний дээжийг тус тус авч Мал эмнэлгийн хүрээлэнд хүргүүлж ажиллалаа.

МХЕГ-ын 01/98 дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт хүнсний худалдааны чиглэлийн үйл ажилагаа эрхлэгч 5 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, бүтээгдэхүүнээс дээж авч аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээний дүнгээр эерэг үзүүлэлттэй гарсан 2 нэр төрлийн 6.5 кг бүтээгдэхүүнийг хураан авч газар дээр нь устгах арга хэмжээг авч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Цагааннуур суманд байрлах “Баян дулаан уул” ХХК-ий үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Б.Дашрэнцэн, хоол үйлдвэрлэлийн 3 ажиллагсад, Ерөө сумын 2 дугаар багт байрлах “Болд төмөр ерөө гол” ХХК-ий Баянгол уурхайн дарга Ж.Мөнхбаатар, эрүүл ахуйч Э.Мөнхжаргал, хүнсний технологич Д.Энхтуяа, хоол үйлдвэрлэлийн 6 ажиллагсад “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал” MNS CAS RCP39:2011 стандарт”, Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмж, Хоол үйлдвэрлэлийн газарт мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм, хоол хүнс, түүхий эдийн чанар, хадгалалт, тээвэрлэлт, технологи, тоног төхөөрөмжийн шаардлага, хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэхэд

анхаарах асуудлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч бэлэн байдлыг тус тус хангуулан ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газарт ирсэн мэдээллийн дагуу МХЕГ-ын даргын 2020 оны 01/75 дугаар удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийхэд Шаамар сумын нутаг дэвсгэрт Дархан Уул аймгийн Дархан сумын 17 дүгээр баг, 21 хороолол, 17 байр 33 тоотод оршин суугч Ядамжавын Цэрэндэжид нь БНХАУ-д үйлдвэрлэсэн, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, чанарын баталгаажуулалтгүй эм бэлдмэл ил задгай худалдан борлуулж байсан тул Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 300 нэгжээр шийтгэлийн арга хэмжээ авч, нийт 8 нэр төрлийн 58 ширхэг 388500 төгрөгийн эм, эмийн зүйлсийг хурааж, Аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлж ажиллалаа.

### **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Сүхбаатар, Орхонтуул, Түшиг, Мандал, Шаамар, Алтанбулаг сумын 11 аж ахуйн нэгж, иргэний 1 хүнсний мухлаг, 3 хүнсний дэлгүүр, 1 минимаркет, 1 цайны газар, 2 кафе, 1 зоогийн газар, 1 баар, 1 үсчний газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгож ажиллалаа.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг 23 үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ явуулдаг иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулан хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, үс засах үйлчилгээнд тавих шаардлага MNS 5160:2020 стандартын сургалт зохион байгуулж ажиллалаа.

*Эзлэхүүн хэмжлийн төрлөөр:* 1 байгууллагын хүсэлтийн дагуу шингэний тоолуурт шалгалт тохируулга хийж, 2 айл өрх, байгууллагын 4 усны тоолуурыг шалган баталгаажуулах ажлыг хийлээ.

*Механикийн хэмжлийн төрлөөр:* Ургац хураалтын бэлэн байдлыг хангуулах зорилгоор автомашины жин шалган баталгаажуулах ажил хийгдэж, нийт 13 автомашины жин хамрагдаад байна. Худалдаа үйлчилгээнд ашиглагдаж байгаа 54 жингээс 16 авто машины жинг шалган баталгаажуулсан. Мөн массын хэмжлийн төрлөөр “Алтан тариа” ХХК-ий технологи, чанар хяналт сорилтын лаборатори, “ТЭД” сан, Мал эмнэлэгийн 12 лабораторийн жин, 12 ш туухай нийт 24 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийлээ.

*Цахилгааны хэмжлийн төрлөөр:* 2020 оны гэрээний дагуу Мандал, Сайхан сумдад “ДСЦТС” ХК-ний лабораторитой хамтран 1 ба 3 фазын 328 цахилгааны тоолуур баталгаажуулалтад хамруулсан.

*Дулаан даралтын хэмжлийн төрлөөр:* Ерөө сумын Эрүүл мэндийн төвийн 1ш эмнэлэгийн термометр, 1ш цусны даралтын аппаратыг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Өнгөрсөн сард 1429 баримтаар 7591600 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Сангийн яамнаас төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системийг хэрэгжүүлж байгаатай холбоотой 45 төсөвт байгууллагуудын дансны жагсаалт болон байгууллагын дарга нягтлан бодогчдыг бүртгэж цалингийн нэгдсэн системийн бүртгэлд оруулж дансанд холбох ажлыг зохион байгуулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

Аймгийн 08-р сарын орлогыг татварын хэлтэстэй тулган баталгаажуулсан.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтын санхүүжилтыг сум бүрт хуваарилж тавьсан.

08 сарын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг олгосон.

Даатгалын байгууллагуудад аудит хийх эрх олгох сургалтанд хамрагдсан 2 хүнээс тестээр шалгалт авч шалгалтын материалыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн.

Монгол банкнаас зохион байгуулж буй “Халаасанд бус хэтэвчинд-овоонд бус гүйлгээнд” аяны хүрээнд орон нутгийн банкуудтай хамтран зурагт хуудас болон шторкийг Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр болон аймгийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж ажилласан.

#### 1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>67,670,994,3</b>	<b>61,763,615,5</b>	<b>91,3</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>14,960,954,0</b>	<b>14,452,182,9</b>	<b>96,6</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	11,460,668,2	10,549,215,5	92,0
	Сумдын төсвийн орлого	3,500,285,8	3,902,967,3	111,5
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,556,395,6	4,556,935,2	100,0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	37,664,788,3	34,941,742,5	92,8
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	4,810,778,4	3,811,681,3	79,2
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	3,242,260,1	3,242,260,1	100,0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	758,813,5	758,813,5	100,0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,677,004,4	563,860,5	33,6
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>67,670,994,3</b>	<b>52,002,644,0</b>	<b>76,8</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>67,670,994,3</b>	<b>52,002,644,0</b>	<b>76,8</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	13,225,638,0	9,687,373,6	73,2
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2,082,596,3	1,168,732,2	56,1
	Сумдын сум хөгжүүлэх сан	10,109,532,3	7,917,817,8	78,3
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	1,505,088,8	568,337,2	37,8
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	2,594,512,0	1,877,727,6	72,4

	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	236,576,0	94,372,4	39,9
	Халамжийн сан	236,576,0	94,372,4	39,9
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	<b>5,471,004,1</b>	<b>5,078,951,6</b>	<b>92,8</b>
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	302,351,4	298,429,0	98,7
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	41,496,159,1	32,516,927,3	78,4
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	757,068,6	711,793,1	94,0
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>53,129,832,6</b>	<b>47,635,210,0</b>	<b>89,7</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	10,654,265,9	8,881,786,3	83,4
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,810,024,3	1,1810,024,3	100,0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	94,228,0	94,228,0	100,0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	1,715,796,3	1,715,796,3	100,0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,000,754,1	2,001,657,0	66,7
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2,659,597,3	1,762,000,2	66,3
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	619,500,0	218,000,0	68,2
	Усан хангамжийн татаас	21,656,8	21,656,8	100,0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	36,953,689,9	34,230,687,2	100,0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	711,098,4	711,055,3	100,0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	37,664,788,3	34,941,742,5	92,8
	- Ерөнхий боловсролын сургууль	20,523,865,5	19,683,299,0	95,9
	- Хүүхдийн цэцэрлэг	11,307,513,1	10,077,688,6	89,1
	- Эрүүл мэндийн байгууллага	5,018,912,0	5,018,912,0	100,0
	- Газрын кадастрын байгууллага	410,816,5	410,816,5	100,0
	- Хүүхдийн байгууллага	403,681,2	403,638,1	100,0
<b>4. Тусгай сангуудын зарлага</b>		<b>1,677,004,4</b>	<b>563,860,5</b>	<b>33,6</b>
4.1	Сумдын сумхөгжүүлэхсан	<b>1,677,004,4</b>	<b>563,860,5</b>	<b>33,6</b>

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөнхэрэглээний барааны нэртөрөл	2019	2020	2020- 08
	08- сар	08- сар	2019-08
Х/төгрөгөөр/			
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>			

<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 600	104.0
	Будаа /кг/	2 400	2 600	108.3
	Элсэн чихэр /кг/	2 200	2 000	90.9
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	7800	7 500	96.2
	Үхрийн мах /кг/	8800	8800	100.0
	Адууны мах /кг/	7 000	7 000	100.0
	Ямааны мах /кг/	7 000	6 800	97.1
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	110.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 000	800	80.0
	Сүү / савласан, л/	2 700	3200	118.5
	Тараг /задгай, л/	1 300	1 000	76.9
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	1 000	2500	200.0
	Лууван /кг/	1 100	2 000	181.8
	Манжин /кг/	1200	3 000	250.0
	Байцаа /кг/	1500	2 500	166.7
	Сонгино /кг/	1 200	1200	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 500	128.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	3 000	107.1
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 750	1 420	81.1
	Бензин А - 92	1 850	1 470	79.5
	Дизелийн түлш	2 370	2 990	88.2

**Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгаж 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэвийн горимд шилжүүлж, сум агентлагуудад хүргэж ажилласан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа явуулах үүргийг хүлээхээр хуульчилсан. Энэ ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар, “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хууль тогтоомж” төрийн албан хаагч болон эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Монголын Хуульчдын холбоотой хамтран “Сэлэнгэ аймагт Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй багц цаг олгох” сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн Ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Дэлхийн зөн” ОУБ хамтран “Сүүдэр бүү тусга” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж хүүхдийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөллийн, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран бэлгийн хүчирхийллийг 2020, 2021 оны төслийн хүрээнд сургагч багш бэлтгэн, олон нийтэд түгээж хамтран ажилласан.

Мөн аймгийн Засаг даргын 2020 оны 01/725 тоот албан бичгээр аймгийн архивын одоогийн нөхцөл байдалтай уялдуулан архивын зориулалтын барилга барих хэрэгцээ шаардлагын тухай, түүний зураг төсөв хийлгэх, архивын үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгслүүдийг худалдан авахад шаардагдах хөрөнгийг 2021 оны орон нутгийн төсөвт тусгуулахад дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг хүргүүлсэн.

Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвийн 1996-2005 оны 10 ХН, ерөнхий боловсролын сургуулийн 1996-2005 оны 22 ХН, цэцэрлэгийн 1981-2005 оны 24 ХН, зам засвар арчлалтын “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий хөмрөгийн 1981-2012 оны 33 ХН-д эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийж, 5085 хуудас баримтад мастер хувь үүсгэн хөмрөгт байрлуулсан.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Сүхбаатар туг” сонин, Цагааннуур сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хөмрөгийн нийт 29 ХН-ийн 3232 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 2021, хүний нэр 7732, газар зүйн нэр 379, байгууллагын нэр 167 шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Зам засвар арчлалтын “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ий хөмрөгийн 1981-2012 оны 102 ХН-д хэсэгчилсэн тооллого болон нягтлан шалгалт хийж, хөмрөгийн дансны хадгаламжийн нэгжийн бүртгэл, мэдээлэл-лавлагааны ач холбогдолгүй болсон, хадгалах хугацаа дууссан 24 ХН-ийг устгахаар ялган авч тэдгээрт устгах бичгийн жагсаалт үйлдэж ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Мөн тус хөмрөгийн 8 ХН-д сэлбэн засалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 9 сард 297 холбогдогчтой 955,8 сая төгрөгийн хохиролтой, 400 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 128-аар буюу 24,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 50,2 хувьтай байгаа нь өмнөх оноос 2,2 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 9 сард 18587 зөрчил илрүүлсэн нь 13218 зөрчлөөр буюу 28,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 09 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 2485, лавлагаа 11, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 1115, лавлагаа 73 олгож үйлчиллээ.

**09 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:**

- ✓ Төрсний бүртгэл – 219 /эрэгтэй-116, эмэгтэй-103
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 41
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 13
- ✓ Үрчлэлт - 6
- ✓ Эцэг тогтоолт – 11
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 8
- ✓ Нас баралт – 44
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 376
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 129
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 62
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 185
- ✓ Гадаад паспорт олголт – 10
- ✓ Шилжин ирсэн – 543
- ✓ Хот доторх шилжилт – 437
- ✓ Лавлагаа - 1026 тус тус бүртгэгдсэн байна.

**Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:**

2020 оны 09 дүгээр сард зохион байгуулах цахим сургалтын хуваарийг гаргаж, судлагдахуун бүрээр сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн сургалтуудыг цахимаар зохион байгуулалаа.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, сургуулийн өмнөх боловсролын газрын дарга Ж.Мягмар, ерөнхий боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Ч.Энх-Амгалан нар Сэлэнгэ аймагт ажиллаж, Сүхбаатар сумын 3 сургууль, 1 цэцэрлэг, БСУГ-ын үйл ажиллагаатай танилцаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай уулзалт хийж, Ерөө суманд 960 хүүхдийн шинэ сургуулийн шав тавих ёслолд оролцлоо.

Улсын төсөвт 38, төрийн бус өмчийн 3, албан газрын харьяат 3, нийт 44 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, 2-5 насны 7535 хүүхэд хамрагдаж байна. 2020.09.21-ний өдрөөс эхлэн 2 настангуудын авч, 1449 хүүхэд хамрагдсан гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын 1,2 дугаар цэцэрлэгүүдийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил болон хоол үйлдвэрлэлийн явц, хоол хүнсний шим тэжээллэг байдалд хяналт тавьж, зөвөлгөө мэдээллээр хангаж ажиллалаа.

БШУЯ-ны 5/1116 “Тушаал, чиглэл хүргүүлэх тухай”, БШУ-ны сайдын А/62 “Хүүхэд харах үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” тушаалыг өмнө нь хүүхэд харах үйлчилгээ ажиллуулж байсан хүүхэд харагч нарт хүргүүлэн зөвлөн тусалж ажиллалаа.

БСУГ-ын шагналаар “Арга зүйч” 64, “Ахлах багш” 56, “Багшийн алдар” 32, “Бүтээлч багш” 4, “Бүтээлч ардын авьяастан” 5, “Бүтээлч соёлын ажилтан” 7, “Шилдэг уран бүтээлч” 2, “Шилдэг багш” 5, “Шилдэг номын сан” 3, “Боловсролын

төлөө медаль” 13, “Ахмадын алдар” шагналаар 15 багшийг тус тус шагнуулахаар шийдвэрлэж холбогдох байгууллагад материалыг хүргүүлэн ажилласан.

БМДИ-ээс 09.01-09.25-ны өдөр зохион байгуулсан “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” цахим сургалтад Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, номын санч 53 хүнийг хамруулж ажиллалаа.

"Суурь боловсролын чанарыг ахиулахад МХТ-ийг оновчтой ашиглах нь" төслийн хүрээнд 6 судлагдахуунаар DVD хичээл боловсруулах, сайжруулах, турших ажлыг зохион байгуулж багийн гишүүд МУБИС-ийн мэргэжлийн багш нартай хамтран ажиллаж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас зохион байгуулсан “Дотоод хяналт шалгалт хийх арга зүй” сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 21, цэцэрлэгийн 17 хүн оролцож, байгууллагынхаа үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалт хийх удирдамж боловсруулах, хэрэгжүүлэх арга зүйд суралцлаа.

Аймгийн ИТХ-аар боловсролын салбарын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хянаж, төсөвт зохицуулалт хийж, хэлэлцүүлэн батлуулсан.

Аймгийн Засаг даргын захирамжийн “Соёлын цаг аян”-ыг аймгийн хэмжээнд 2020.09.04-2020.10.20-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, тус аяны хүрээнд орон нутгийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулахад чиглэсэн урлаг, уран сайхан, номын сан, музей, орон нутаг сурталчлах танхимын явуулын үйлчилгээ, хүүхэд залуучуудад зориулсан тусгай арга хэмжээг төлөвлөж, зохион байгуулан ажиллаж байна.

/COVID-19/халдвараас урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэлийг зааварчилгааны дагуу Сэлэнгэ биеийн тамир спортын газрын спорт заал, албан бичгийн өрөө, сургалтын танхимууд, ариун цэврийн өрөө, гадна талбай нийт 2412 кв талбайд хийж гүйцэтгэлээ.

9 дүгээр сарын 1-ний өдрөөс “Дасгалаар дархлаагаа дэмжье 2” аяныг өрнүүлж, аянд нийт 162 хүн хамрагдаж байгаагаас оролцогчдыг урамшуулах зорилгоор 2 удаа сугалаа зохион байгуулж 6 хүн азтанаар шалгарлаа.

## **2.Эрүүл мэндийн талаар:**

Эрүүл мэндийн яамнаас 2020 оныг “Сувилагч-Эх баригч”-ийн жил болгон зарласантай холбогдуулан Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/40 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж “Сувилагч солилцоо” аяныг зохион байгууллаа. Энэхүү аянд 17 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн байгууллагын ахлах сувилагч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нийт 28 эмнэлгийн мэргэжилтэнг ажлын байранд хуваарийн дагуу солилцон, удирдлага манлайллыг сайжруулах, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжид шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Багшийн хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 145 дугаар тогтоолд Боловсролын сургалтын байгууллагын багш ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газрын дарга нарын хамтарсан удирдамжийн дагуу тус сард эрүүл

мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт боловсролын байгууллагын 2916 багш, ажилчдыг хамруулахаас 2682 буюу 92%-тай хамруулж ажилласан.

Үзлэгийг сонгон шалгаруулалтанд тэнцсэн Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сум дахь Нэгдсэн эмнэлэг, Сайхан суман дахь Хөтөл сум дундын эмнэлэг, “Ханжи-Оч” лабораториудтай хамтран бүсчлэн зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын багш ажилчдад дараах нэр төрлөөр үзлэг, оношлогоог хийсэн. Үүнд:

- Дотор зүрх судасны үзлэг
- Эрэгтэйчүүдийн үзлэг
- Эмэгтэйчүүдийн үзлэг
- Бэлгийн замын дархлал хомсдлын эмчийн үзлэг
- Сүрьеэгийн эмчийн үзлэг
- Рентген үзлэг
- ЭХО үзлэг
- Биеийн жингийн илүүдэл тодорхойлох үзлэг
- Цусан дахь сахарын үзлэг
- Бэлгийн замын дархлал хомсдлыг илрүүлэх
- Цусан дахь холестерин тодорхойлох үзлэг

Өвчлөлийг өвчний оношоор нь авч үзэхэд тэргүүлэх 3 өвчлөл харагдаж байна. Үүнд:

1. Бөөрний архаг үрэвсэл
2. Нойр булчирхайн архаг үрэвсэл
3. Артерын даралт ихсэлт зонхилон тохиолдож байна.

**3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:**

Халамжийн санд улсын төсвөөс 37632 иргэнд 11564982,0 мян.төг-ийг зарцууллаа. Үүнд:

**Орон нутгийн төсвийн орлогоос:** /9 дүгээр сарын байдлаар/

- Онцгой тохиолдлын тэтгэмжид 22 иргэнд 26400,0 мян.төг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 390 иргэн хамрагдаж 64837,9 мян.төголгоод байна.

**Улсын төсвийн орлогоос:** Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 37220 иргэнд 11473744,1 мян.төг-ийг олгоод байна.

**Үүнд:**

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2481 иргэнд 4317395,2 мян.төг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1814 иргэнд 1106174,2 мян.төг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1718 иргэнд 700940,2 мян.төг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 1954 эхэд 261496,6 мян.төг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5950 эхэд 1842805,0 мян.төг
- Өрх толгойлсон эх/эцэгийн тэтгэмж 236 иргэнд 179663,1 мянган төг
- Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 3177 ахмадын 311015,7 мян.төг
- Алдар цолтон ахмад настанд 59 ахмадын 60690,2 мян.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 364 иргэний 77011,2 мян.төг

- Алдарт эхийн одон 8656 эхэд 1107300,0 мян.төг
- Насны хишиг үйлчилгээг 5047 ахмадад 762580,0 мян.төг
- Ихэр хүүхдийн тэтгэмж 22 хүүхдэд 44000,0 мян.төг
- Хүнсний эрхийн бичгийн 5740 иргэнд 702673,0 мян.төгрөгийг зарцууллаа.

Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 09 дүгээр сарын байдлаар 21.1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 29-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 25.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 121.69 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нийт 5 хурал хийж, 495 хүн орсноос 369 хүн актыг сунгаж, 81 хүн шинээр тогтоож, 45 хүний актыг цуцалсан байна.

- Тэтгэврийн даатгалын сангаас 17596 тэтгэвэр авагчдад 54,259,626 мянган төгрөг
- Тэтгэмжийн даатгалын сангаас 3973 хүнд 2,182,477 мянган төгрөг
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 247 хүнд 774237 мянган төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 277 хүнд 735,497 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг 2020 оны 09 дүгээр сард 995 лавлагааг иргэд, аж ахуй нэгжид цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчлэн ажиллалаа.

#### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

“Олон улсын залуучуудийн өдөр”-ийг тохиолдуулан “Нэг залуу, нэг санал” уриан дор 17 сум 6 тосгоны Залуучуудын элч бэлтгэх сургалтанд 22 хүн хамруулж, Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх сумдын салбар зөвлөлийг байгууллаа.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төлөвлөх, хөдөлмөрөөс хөндийрүүлэхэд чиглэгдсэн тандалт судалгааны хүрээнд Сүхбаатар, Хүдэр, Ерөө, Баянгол, Сайхан, Мандал сумын бичил уурхайгаар ашигт малтмал олборлох 10 нөхөрлөл, 5 аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний 400 гаруй аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэгч хүүхэд байгаа эсэхэд хяналт тавьж ажиллалаа.

Хүүхдийн тусламж үйлчилгээний 108 утасны төвөөс 8 дуудлага мэдээллийг хүлээн авч хамтарсан багт шилжүүллээ.

- Сэтгэл санааны хүчирхийлэл 2
- Бие махбодын-2
- Үл хайхрах-3

**Хүчирхийлэл үйлдэгдсэн орчин:** Гэр бүлийн орчинд

#### **Эрсдэлийн түвшингөөр**

- Дунд эрсдэлтэй-1
- Бага эрсдэлтэй-7, үүнээс 4 тохиолдлийг хяналтад авч ажиллаж байна.

### **Тав.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 тоот тогтоолын 1-р хавсралт, аймгийн Засаг даргын А/110 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 600000 толгой мал, амьтан (боом 530.0, томуу 30.0, галзуу 28.0, ГСМ 12.0 толгой) хамрагдахаас технологит хугацаанд 598000 толгой мал, амьтан (боом 535000, томуу 15000, галзуу 28000, ГСМ 12000 толгой) буюу 99,2 хувийг хамруулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/110 тоот захирамжаар МУЗГ-ын 225 тоот тогтоолын 2-р хавсралтаар санхүүжүүлэх тарилганд давхардсан тоогоор 200200 толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 200200 толгой мал, амьтан (Дотрын халдварт хордлого 18000, дуут 90000, цусан халдварт 80000, тугалын иж балнад 6200, гахайн цусан халдварт 6000 иж балнад толгой) буюу 100 хувьтай байна. МУЗГ-ын 225 тоот тогтоолын 3-р хавсралт дахь иргэд, ААНБ-аас төлбөр авах тарилганд давхардсан тоогоор 390000 толгой мал хамрагдахаас 39.0 мянган (шөвөг яр 365000, сахуу 25000 толгой) толгой мал, амьтан хамрагдаж, гүйцэтгэл 100 хувьтай байна.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/182 тоот тушаалаар батлагдсан “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” тушаалын дагуу үхэр, хонь, ямааны охин төлийг хамруулахаар батлагдсаны дагуу тугал 51440 толгой хамрагдахаас 51440 буюу 100 хувь, богийн төл 370300 толгой хамрагдахаас 370300 буюу 100 хувь нийт 421740 толгой төл мал буюу 100 хувь хамруулсан.

Аймгийн Засаг даргын А/110 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжаар шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээний угаалганд технологит хугацаанд давхардсан тоогоор нийт 3483728 толгой мал, амьтан хамруулахаас энэ сард 1436500 толгой мал, туулгалтанд 3596340 толгой мал хамруулахаас 765200 толгой мал, боловсруулалтад 715337 мал, амьтан хамруулхаас 121500 толгой мал, амьтан нийт 2323200 толгой мал амьтан хамруулж, гүйцэтгэлийг цахим нэгдсэн системд тайлагнаж ажилласан.

Шүлхий, бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх, эмнэлзүй болон ийлдэс судлалын тандалт шинжилгээг улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой хамтран баталсан удирдамжийн дагуу эпидемиологийн тооцоонд тулгуурлан санамсаргүй түүврийн аргаар шүлхий өвчний тандалт шинжилгээнд Мандал, Алтанбулаг, Шаамар сумдын 30 өрхийн нийт 450 малын сорьц дээж, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээнд Баруунбүрэн, Орхонтуул, Мандал, Сант, Алтанбулаг сумдын 50 өрхийн 700 бог малын сорьц дээж цуглуулан, хот айл бүрийн мэдээлэл, хот айлын асуумж болон сорьц дээжийн бүртгэл, газар зүйн байршил уртраг, өргөрөгийг гар утсанд суурилсан тусгай программ болох LIMS болон цаасан хэлбэрээр бүртгэж, цахим бүртгэлд оруулан шинжилгээг хийж ажиллалаа. Мал эмнэлгийн лабораторийн Чанарын удирдлагын тогтолцооны MNS ISO/IEC17025:2018 шинэчилэгдсэн стандартын дагуу лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага, стандартыг үйл ажиллагаандаа байнга нэвтрүүлж, итгэмжлэлээ бататгах, мөн био аюулгүй байдлыг тодорхойлох, хяналт судалгаа хийх зорилгоор төлөвлөгөөт дотоод аудитыг ариун цэвэр магадлан шинжилгээ, нян судлал, паразит судлал, ийлдэс судлалын тасгуудад 1 удаа хийж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/98 тоот захирамжийг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар гамшгийн штабын дарга буюу сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, аймгийн Мал эмнэлгийн газраас мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангаж, сум бүр өөрийн онцлогт тохируулан ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж, 17 сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн, МЭТ, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг хамруулсан удирдах ажилтан 88, МЭТ-ийн тархвар судлаач, Мал эмнэлгийн улсын байцаагч, малын эмч 60, туслах ажилтан 275, малчин, мал бүхий иргэн 6668, нийт 7091 хүн оролцож, малчин, мал бүхий ард иргэдийн малын хашаа, гахай, тахиан байр, өвөлжөө, хаваржаа, өтөг бууц, худаг уст цэгийн 897600 м<sup>2</sup>, малын бэлчээр 43900 м<sup>2</sup>, мал, амьтын гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүн хадгалах зоорь, агуулах цэгийн 42800 м<sup>2</sup>, албан байгууллага, хилийн боомтын талбай, төмөр зам болон авто зогсоол, нийтийн эзэмшлийн талбайн 90265 м<sup>2</sup>, элдэв хордлого, байгалийн нөлөөлөл, механик гэмтлээс болж үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм 14787 ширхэгийг булж устган орчны ариутгалд 100500 м<sup>2</sup>, нийт 1992700 м<sup>2</sup> талбайд халдварт өвчний гадаад орчинд тархах зам, эмгэг төрүүлэгч бичил биетнүүдийн тэсвэрт чанар, орчны физик, химийн бүтэц, халдваргүйжүүлэгч бодисын шинж чанар түүний гадаад орчин болон эмгэг төрүүлэгч бичил биетэнд нөлөөлөх байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж хлорын шохой, HiCOP, Ваймекон, супер килл зэрэг ариутгал халдваргүйтгэлийн бодисоор малын эмч нар гардан гүйцэтгэж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг тогтмол хэрэглэж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

## **2. Хөдөө аж ахуйн талаар:**

Аймгийн хэмжээнд хаврын тариалалтад үр тарианы 251 аж ахуй нэгж, 105 иргэн, төмс, хүнсний ногооны 95 аж ахуйн нэгж, 2251 иргэн 181.0 мянган га талбайд тариалалт хийсэн.

Тариалалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, тариалалтын эцсийн мэдээгээр 161.7 мян.га талбайд үр тариа тариалсанаас улаанбуудай 153.7 мян.га буюу 109 хувьтай, 958 га-д арвай, 4106 га-д овьёос, 1750 га гурвалжин будаа, тэжээлийн ургамал 8027 га буюу 70 хувьтай, тосны ургамал 25.3 мян.га буюу 141 хувьтай, төмс 2822 га буюу 112 хувьтай, хүнсний ногоо 2829 га буюу 108 хувьтай тариалсан байна.

Мөн Сэлэнгэ аймгийн өрх бүр өөрсдийн хэрэгцээний төмс, хүнсний ногоогоо тарьж ургуулан өрхийн хэрэгцээгээ хангахыг уриалан төмс, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ хөдөө” төслийн хүрээнд төмс, хүнсний ногооны үр олгох, Өсвөрийн хээлтүүлэгч олгох, Ногоон тэжээлийн үр олгох, Хүлэмж олгох гэсэн 4 багц тендерийг зарлаж, 4 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан ажиллаж байна.

Газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэн энэ цаг үед, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангамжийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх, дотоодод үйлдвэрлэх, 2020 оны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас олгох 150.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамруулахаар үр тарианы 277 аж ахуй нэгж, 160 иргэн, төмс, хүнсний ногооны 95 аж ахуйн нэгж, 2251 иргэний судалгааг авч Хүнс, хөдөө аж

ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлан арилжааны банкуудаар зээл олгогдож эхлээд байна.

Аймгийн хэмжээнд 2020 онд 340 иргэн, аж ахуйн нэгж 110,0 мянган га-д талбайд уринш боловсруулж, 49.6 мян,га талбайд механик уринш, 60.3 мянга талбайд уриншийн боловсруулалт хийсэн байна.

2020 оны урьдчилсан ургац тогтоолтоор улаанбуудай 2417 га талбай ургац алдаж, 148.0 мян.га талбай хураахаас нэгж га талбайгаас 13.2 цн буюу 194.8 мян,тн, тэжээлийн ургамал 10 га талбай ургац алдаж, 12774 га талбай хураахаас нэгж га талбайгаас 13 ц,н буюу 16811 тн, тосны ургамал 572 га талбай ургац алдаж, 24010 га талбай хураахаас нэгж га талбайгаас 6 цн буюу 16318 тн, төмс 29 га талбай ургаж алдаж, 2846 га талбай хураахаас нэгж га талбайгаас 97 цн буюу 27543 тн, хүнсний ногоо 37 га талбай ургац алдаж, 3017 га талбайгаас хураахаас нэгж га талбайгаас 102 цн буюу 30871 тн хураан авах төлөвтэй байна.

Ургац хураалтад 403 комбайн, 101 будаа цэвэрлэгч, 157 будаа ачигч, 32 төмсний комбайн, 5 даршны комбайн, 39 төмс ухагч, 32 хүнсний ногоо хураагч, 22 механикжсан үртрэм ажиллахад техник засвар үйлчилгээний ажил хийгдэж, техникийн бэлэн байдал 92.8 хувьтай байна.

Төмс, хүнсний ногооны хувь хураалтын ажил 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн эртийн хүнсний ногоог худалдаанд гаргасан, 9-р сарын сүүлийн байдлаар 5124 тн хүнсний ногоо, 1235 тн төмс хураан зах зээлд нийлүүлсэн мэдээтэй байна.

“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 15 дах жилдээ зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд-2020” үзэсгэлэн худалдаанд манай аймгаас Мандал /5/, Жавхлант /2/, Сүхбаатар /5/, Зүүнбүрэн /9/, Баруунбүрэн /1/, Шаамар /16/ , Орхон /1/ , Хушаат /2/ сумдын нийт 41 ногоочид оролцож, төмс, хүнсний ногоо, даршилсан ногоо, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүн борлуулж нийт 287 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2000 тн өвс, 600 тн тэжээлийг аюулгүйн нөөцөд бэлтгэж малчдын түвшинд 191596 тн байгалийн өвс, 40874 тн үйлдвэрийн тэжээл, 10218 тн давс, хужир, шүү бэлтгэхээс 9-р сарын 25-ны өдрийн байдлаар 35 мян тонн байгалийн хадлан, 2072 тн ногоон тэжээл, 20000 тн дарш, 49 тн эрдэс тэжээл бэлтгэж малчдын түвшинд хадлангийн бэлтгэлийн ажлын явц 18.3 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.1.12 дахь заалтыг хэрэгжүүлэх, Газар тариалангийн бүс нутагт тохирсон өндөр ашиг шимт малыг өсгөн үржүүлж тооноос чанарт шилжих, эрчимжсэн, хагас суурин мал аж ахуй эрхлэх мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж буй малчид, фермерүүдийн уялдаа холбоог сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах бодлогын хэрэгжилтийн дагуу дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн түүнд түшиглэсэн эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхэлж байгаа Цагааннуур сумын “Баяндулаан-Уул” ХХК-ий талбайд “Газар тариалангийн салбарын техник, технологийн шинэчлэл-эрчимжсэн мал аж ахуй” өдөрлөгийг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд “Үндэсний үйлдвэрт хонь, тэмээний ноос тушаасан 1979 малчин, мал бүхий иргэдийн нийт 548,961 кг үүнээс 1-р зэргийн 474,469 кг, бусад 74,492 кг ноосны материалыг нэгтгэн, мэдээллийг ноосны урамшууллын нэгдсэн системд оруулж “Хөдөө аж ахуйг дэмжих сан”-д дамжуулан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн зурвас газарт 102 малчин өрхийн 59226 толгой мал отроор өвөлжиж, хаваржих судалгаа гаргаад байна.

### **3. Байгаль орчны талаар:**

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Алтанбулаг, Мандал, Ерөө сумдад хийгдсэн 250 га талбай, ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтын ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

БОАЖЯ-аас “Хандлагаа өөрчилъе” багц ажил, “Хоггүй цэвэрхэн Монгол аян”-ыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд манай аймаг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 10.000.000 төгрөгийн санхүүжилттэйгээр 5 ажил зохион байгуулж байгаагийн нэг нь “Хоггүй цэвэрхэн сум болцгооё” уралдаан юм. Уралдааны удирдамжийг газрын даргаар батлуулж, 17 сум, 6 тосгонд хүргүүлээд байна. Аймгийн хэмжээнд 4 аж ахуйн нэгж, байгууллага, 4 айл өрхийг шалгаруулна. Уралдааны нийт шагналын сан 2.600.000 төгрөг юм.

Аймгийн Цагдаагийн газрын Экологийн албатай хамтран Орхонтуул сумын нутаг дэвсгэрт ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын хууль бус үйлдлийг бууруулах, таслан зогсоох зорилгоор хяналт шалгалт хийж, шалгалтаар бичиг баримтын бүрдэлт, үйл ажиллагаа явуулсан талбайг хэмжиж, фото зургаар баримтжуулан аймгийн Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/168 тоот захирамжийн дагуу аймгийн Татварын хэлтэстэй хамтран Түшиг, Орхонтуул, Баянгол, Сайхан сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Тод-ундарга” ХХК, “Бороо гоулд” ХХК, “Түшиг индустрал” ХХК-иудаас 87.560.200 төгрөгийг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан. Усны орлого 401.563.520 төгрөгийн биелэлттэй байна.

Ерөө, Мандал, Хүдэр, Цагааннуур сумдаас түүж буй хуш модны самрын төлбөрийн хэмжээг авч нэгтгэсэн. Ерөө суманд 380 сая төгрөг, Хүдэр суманд 420 сая төгрөг, Баруунбүрэн суманд 180 сая гаруй төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөөд байна.

Сайхан сумын Хөтөл-1, 2 нэртэй газар ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Цемент Шохой” ХК-ий ТЭЗҮ, БОНБНУ, 2020 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, ус ашиглах дүгнэлт, гэрээ зэрэг бичиг баримтын бүрдэлтэй танилцаж хянан бүртгэх хуудас олгож ажиллалаа.

“Байгаль эн тэргүүнд” аяны хүрээнд Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Хулгайчийн булаг, Ханын хөндий, Мойлтын ам зэрэг газруудаар Сүхбаатар сумын байгаль орчны хяналтын байцаагчтай хамтран хийж, шалгалтаар Сүхбаатар сумын IV багийн иргэн Т зөвшөөрөлгүй түлшний мод бэлтгэж тээвэрлэж явсныг илрүүлэн хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан.

### **4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:**

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны А/40 тоот тушаалаар “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем

ажиллуулах журам” батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2020 оноос сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг уг системд оруулж баталсны үндсэн дээр иргэн хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэдэг болсон. Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 28 нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан. Мөн Сүхбаатар сумын 75 иргэнд шинэчилсэн хаягаар кадастрын зургийг үнэт цаасан дээр хэвлэн иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Банк болон банк санхүүгийн байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалан зээл авч байгаа 20 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн барьцааны бүртгэлийг газрын цахим биржид бүртгэлжүүлэн 16 иргэн аж ахуйн нэгжийн барьцааг чөлөөлж газрын мэдээллийн санд холбон ажилласан.

Ерөө, Алтанбулаг, Зүүнбүрэн сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан газар эзэмших эрхийн дуудлага худалдааг зохион байгуулахаар дуудлага худалдааны зарыг газрын цахим бирж, “Зууны мэдээ” сонинд тус тус байршуулсан.

Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багийн 2 нэгж талбар, Баянхаан 4-р багийн 4 нэгж талбар, Салхит 3-р багийн 6 нэгж талбарыг хаягжуулалтын журмын дагуу дугаарлан, Хонгор морьт 1-р багийн 1 нэгж талбарт нэр өгч аймгийн мэдээллийн санд бүртгэсэн.

Газрын кадастрын мэдээллийн санд “Sky networks”, “Mobicom networks” ХХК-ий газар доорх шилэн кабелийн шугамын зургийг баталгаажуулж ажилласан. Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн шинэчлэлт, баяжуулалт хийх ажлын хүрээнд 17 сум 6 тосгоны газар доорх, дээрх шугам сүлжээ, барилга байгууламжийн мэдээллийг 192.168.10.37 серверт баяжуулсан. 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зургийг нэгтгэж MNS 6702:2017 стандартын хэлбэрт хөрвүүлэх талаар суралцаж, 17 сум 6 тосгоны байр зүйн тоон зургийг нэгтгэж ажиллалаа.

➤ **УЛСЫН КОМИССЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, БАЙНГЫН АШИГЛАЛТАД ХҮЛЭЭЛЦҮҮЛСЭН БАЙДАЛ:**

- “Тийм Эттэ” ХХК-ий гүйцэтгэсэн “Прокурорын барилгын дээвэр засвар”-ын ажил
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд “Сэлэнгэ таванхан” ХХК-ий гүйцэтгэсэн Цэнхэрийн 15, 16, 17, 18-р байрны тоглоомын талбай
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Жи Ти Кэй Эс” ХХК-ий гүйцэтгэсэн “Нутгийн захиргааны 3 дугаар байрны сантехник”-ийн их засвар
- Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт “Тийм Эттэ” ХХК-ий гүйцэтгэсэн “Ахмадын байр”-ны засварын ажил
- Сүхбаатар сумын 2, 3, 8 дугаар багийн нутаг дэвсгэрт “Сэлэнгэ АЗЗА” ХХК-ий гүйцэтгэсэн авто замын ажил
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Бадрах мандал шим” ХХК-ий гүйцэтгэсэн Сайхан сумын 1-р сургуулийн сантехникийн их засварын ажил

- Баянгол сумын нутаг дэвсгэрт “БИММ” ХХК-ий гүйцэтгэсэн “Инженерийн шугамтай гүний худаг гаргах” ажил, “Нобель роуд” ХХК-ий гүйцэтгэсэн “Хараа голын дагуу үерийн далан суваг” хийх ажил, хайрган хучилттай зам сэргээн засварлах ажил
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын 2-р багийн нутаг дэвсгэрт “Перфект смайл” ХХК-ий гүйцэтгэсэн орон сууцны гадна талбайн тохижилтын ажил
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянгол суманд баригдсан “400 хүний суудалтай соёлын төв”-ийн барилгын ажилд тус тус улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлж ажилласан.

Барилга, Хот байгуулалтын Сайдын 2020 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах, ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/96 тоот тушаалаар “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн өгөгдөл бүрдүүлэх инженерийн дэд бүтцийн цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, хот тохижилт, ногоон байгууламжийн авто зогсоол, усан оргилуур, явган болон дугуйн зам, хөшөө дурсгал, гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээлэл бүртгэх маягт батлагдсан ба эдгээр маягтаар хөгжүүлсэн байрлалд суурилсан цахим вэб програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын программд нийт 354 барилга байгууламжийн мэдээллийг тус бүрийн дөрвөн талт зургийн хамт архивлан ажиллалаа.

### **Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сум:**

Коронавируст халдварын цар тахлаас хамаарч онцгой нөхцөл байдалд 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт үйл ажиллагаа эхлэж байгаатай холбогдуулан түр журмын дагуу хүүхдийн бүртгэл, эрүүл мэндийн үзлэг шинжилгээг сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран бөөгнөрөл үүсгэхгүй зохион байгуулж, 100 хувь хамруулж ажилласан.

2020 оны 09-р сард Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт БСШУСЯ, ЭМЯ хамтарсан тушаал шийдвэрийн дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтан, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илэрүүлгийн үзлэгт хамруулах тухай тушаал, зөвлөмж, аймгийн ЭМГ, БСУГ-ын хамтарсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд багш, ажилчдыг 100 хувь хамруулсан.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан сургуулийн ойр орчмын хүнсний дэлгүүрүүдэд хүүхдэд зарахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнүүдийн жагсаалт, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зөвлөмж өгч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А/40 тоот тушаалын дагуу “Сувилагч солилцоо” аяны хүрээнд сумын Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч Ж.Мядаг Хушаат сумын Эрүүл мэндийн төвд 5 хоног ажиллаж туршлага солилцож ажиллалаа.

#### **Баруунбүрэн сум:**

Цагаан-овооны 3-р багийн Усжуулахын ногооны талбайн хашааг ойролцоох ногоочдод нь хариуцуулан өгч, Багийн Засаг дарга, газрын даамал нартай хамтран малчин болон мал бүхий өрхүүдэд хадлангийн талбайг хуваарилаж сумын хэмжээнд одоогийн байдлаар хадлан бэлтгэлт 70 хувь буюу 7500 тонн хадланг бэлтгээд байна. Хадлангийн ургацын гарц муу байгаатай холбогдуулан малчид болон мал бүхий өрхүүд тариалангийн аж ахуй нэгжтэй тохиролцон тариалангийн талбайг хадаж бэлтгэж байна.

Үр тарианы ургац хураалт эхлээгүй 500 га талбайг ангиласан байна. Төмс, хүнсний ногооны ургац хураалтын явц 60 хувь буюу 108 га талбайгаас 1300 тонн төмс, хүсний ногоо хураан аваад байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд 122446 толгой мал, амьтдыг хамруулахаас 122446 толгой буюу 100 хувь, боловсруулалт 100 хувь, туулга бод, бог, гахай 100 хувь, угаалга бод 79 хувь, бог 86,3 хувьтай байна.

Бруцеллёзын тандалт шинжилгээгээр эерэг гарсан хуц 1, ухна 1-ийг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулан малчин, маллагч нарыг байлцуулан хөнгөлж холбогдох баримт материалыг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн.

КОВИД-19 цар тахлын үед хэрэглэгдэх яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, амны хаалтыг эмнэлгийн ажилчид хүн бүрт 3-5 удаагийн хүрэлцэхүйц хэмжээний нөөц, түргэн тусламжийн машин шатахууны нөөц, орны нөөцийг бэлдэн ажиллаж, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилчид өдөр бүр ээлжлэн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэхээр ирсэн иргэдийн халууныг тогтмол үзэж, тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Мөн цахим орчноор дамжуулан шинэ коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааг тогтмол ард иргэдэд мэдээллэж, 21 нэр төрлийн гарын авлага 570 ширхэгийг хэвлэж үйлчлүүлэгчдэд тараан ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд тус сургууль нь 52 багшажилчид, 519 суралцагчтайгаар хичээл сургалтын үйл ажиллагаа эхлүүлэн явуулж байна. БШУЯ-ны сайдын А/17 түр журмын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Тус сумын 1-р цэцэрлэг нь 2020-2021 оны хичээлийн жилд 23 хүний бүрэлдэхүүнтэй, 6 бүлгийн 141 хүүхдийн хамран сургалттай үйл ажиллагаагаа явуулж байна. 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 195 сая төгрөгийн их засварын ажил хийгдэж, Цэцэрлэгийн гадна талбайн явган хүний зам, биеийн тамирын талбайг тохижуулсан. Мөн БСШУЯ-аас санхүүжүүлсэн 7.400.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн ширээ, сандал, сургалтын шкаф, тавиур, хүүхдийн хувцасны шкаф, угтахын ширээ, багш сандал зэрэг эд хогшил авсан.

“Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүй”-н сургалт, “Сайжруулсан хөтөлбөр, телехичээл”-ийн тухай цахим сургалтад тус тус цахимаар хамрагдсан. Мөн “Нийгмийн даатгал”-ын байгууллагаас зохион байгуулсан сертификаттай сургалтанд байгууллагын 8 албан хаагчийн хамруулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/99 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд /КОВИД-19/ цар тахлын энэ цаг үед хүн амыг биеийн тамир, спортоор идэвхитэй хичээллүүлэн дархлааг дэмжих зорилгоор **“ӨГЛӨӨНИЙ ДАСГАЛ, АЛХАЛТ, ГҮЙЛТ”** сарын аяныг сумандаа хэрэгжүүлж ажилласан.

Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем, “Үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан төрийн үйлчилгээг операторын хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай дэд систем хөгжүүлэх зорилгоор төрийн байгууллагын 52 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэх ажлыг 2020 оны 07-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүргэн ажиллаж, 139 нэр төрлийн лавлагаа олгосон байна.

### **Баянгол сум:**

Дэлхий нийтэд коронавирусын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хэсэгчилсэн зэрэгт 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал Сумын Засаг даргын 2020 оны А/207 тоот Өндөржүүлсэн бэлэн байдлын хэсэгчилсэн зэрэгт шилжүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллалаа.

Оросын Холбооны Улсаас Улаанбаатарын чиглэлд тээвэр хийж явсан автомашины цуваанаас Гонир 3-р баг, 10-р хэсэг, Төмөр замын найман байшин гэх газраар дайран өнгөрөхдөө гадна тоглож байсан хүүхдүүд рүү чихэр шидсэн, түүнийг түүж идсэн тохиолдол илэрсэнтэй холбогдуулан тухайн газарт болон сумын Эрүүл мэндийн төвд сумын Онцгой комисс хуралдан 2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэмийг тогтоож Эрүүл мэндийн төв, Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги, Цагдаагийн хэсэг болон төр, төсвийн байгууллагуудад ариутгал, халдваргүйтлийн ажлыг эрчимжүүлж ажиллах үүрэг чиглэл өгч сумын Засаг даргын 2020 оны А/208 тоот Хорио цээрийн дэглэм тогтоох тухай захирамж гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан дэлхий нийтэд үүсээд байгаа коронавирусийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтэл хийх, бэлэн байдлыг хангах ажилд зориулан сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,080,000 төгрөгийг санхүүжүүлж ариутгал халдваргүйтлийг хийн ажиллаж байна.

Мөн сумын Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу ажлын хэсэг нь ЕБС, 1-р цэцэрлэг, ЭМТ-ийн хоолны эрүүл ахуй, хадгалалт, ариутгал халдваргүйтэлд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аяныг 12-р сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулж байгаатай холбогдуулан төр, төсвийн байгууллагуудад Авлигын эсрэг бэлтгэсэн шторк, богино хэмжээний сургалт, сурталчилгааны материалуудыг хүргүүлж, сумын фэйсбүүк хаягаар дамжуулан иргэдэд мэдээллийг хүргэн ажиллаж байна. 10-12 дугаар ангийн суралцагчдын дунд “Авилга миний нүдээр” эссэ бичлэгийн уралдаан, 6-9 дүгээр ангийн суралцагчдын дунд гар зургийн уралдааныг зохион байгуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу ЗДТГ-аас ажлын хэсэг томилогдон төр, төсвийн байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумын Сонгуулийн хороо, хэсгийн хороод байгуулагдан хуулийн дагуу ажил үүргийг хэрэгжүүлж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/184 захирамжийн хүрээнд өвөлжилтийн бэлтгэл хангах, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг зохион байгуулжмалчин, мал бүхий өрх бүрт цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээлийг бэлтгэх талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/255 тоот захирамжийн дагуу хоёдугаар ээлжийн хугацаат цэргийн албанд татагдах 18-26 насны залууст зарлан дуудах мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

“Соёлын цаг” аяны хүрээнд эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Аялгуу дуутай алтанхан намар” өдөрлөг, цэнгүүнийг зохион байгуулж, урлагийн тоглолт, “Намрын аялгуу” дууны уралдаан, “Намрын амт” үзэсгэлэн худалдаа, нийтийн бүжгийн арга хэмжээ явагдаж 85 эмэгтэй хамрагдсан.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан алслагдсан хөдөөгийн иргэдэд нүүдлийн соёлын үйлчилгээг хүргэх зорилгоор Хараа, Баян, Гонир багийн малчин өрхүүдэд урлагийн тоглолт, дууны уралдаан, нийтийн бүжгийн арга хэмжээг зохион байгуулж 215 хүн хамрагдлаа.

Тус сард Соёлын төвөөс 17 удаагийн соёл, урлаг, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж 1735 иргэн хамрагдсан байна. Номын сангаас 10 удаагийн соёл олон түмний ажил зохион байгуулагдаж 1145 хүн хамрагдан оролцсон.

Сумын Засаг даргын захирамжаар батлагдсан угийн бичиг хөтлөх ажлыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Угийн бичгээ хөтөлж, ураг төрлөө дээдэлье” гарын авлага, материалыг 431 иргэнд тарааж мэдээлэл хүргэн ажилласан.

УОК-оос өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан байгууллагын хариуцлагатай жижүүрийн хуваарийг баталж ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2020 оны 18/02 дугаартай “Хяналт шалгалт хийх” тухай байнгын удирдамжийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. БОАЖЯ-аас “Хандлагаа өөрчилъё” аяны хүрээнд зохион байгуулагдаж байгаа “Хоггүй, цэвэрхэн сум болцгооё” уралдааны удирдамжийн дагуу байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрхийн бичгийг 1 иргэнд 5 тн голын хайрга ашиглах зөвшөөрөл олгож, 12,500 төгрөгийг сумын төрийн санд, түлээ бэлтгэх эрхийн бичгийг 11 иргэнд 72 м.куб улиас, 16 м.куб нарс мод бэлтгэх зөвшөөрөл олгож, нийт 263,900 төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүллээ.

09 дүгээр сарын сүүлийн байдлаар улаанбуудай тариалсан 2487 га талбайг ангилж, 496 га талбайгаас 725 тн улаанбуудай, 46 га талбайгаас 70 тн овъёос, 82 га талбайгаас 984 тн төмс, 74 га талбайгаас 1020 тн хүнсний ногоо хураагаад байна.

Сумын хэмжээнд 2020-2021 онд 186,0 мянган толгой мал өвөлжихөөр урьдчилан тооцоход 16872 тн байгалийн хадлан, 3599 тн тэжээл, 900 тн эрдэс

тэжээл шаардлагатай байна. 2020 оны 09 дүгээр сарын байдлаар өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, хадлан тэжээл бэлтгэх ажил эрчимжиж 130 иргэн 3200 га талбайд хадлан бэлтгэх зөвшөөрөл авч, хадландаа гараад байна. Энэ жил хадлангийн ургац тааруугаас шалтгаалан сумын өвс тэжээлийн нөөцөд шаардлагатай өвс бэлтгэх боломжгүйд хүрч, газар тариалангийн аж ахуй нэгжүүдээс тариалсан талбайн га тутамд 1 кг тэжээлийн будаа авч төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

АДРА олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй Органик хөдөө аж ахуйн төсөл хөтөлбөрт хамрагдаж буй Хараагийн баян үрс, Гонир баян, Түмэн дэвших хоршоодын төмс, хүнсний ногооны борлуулалтын сүлжээг бий болгох зорилгоор төслөөс органик бүтээгдэхүүн борлуулах мухлагыг байгуулж, төрийн зүгээс газрыг нь шийдэн дэмжиж ажиллаж байна.

Мөн ногоочдын борлуулалтын үйл ажиллагааг жилийн 4 улиралд эрхлэх чиглэлээр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй Siset төслөөс санаачлан байгуулсан 4 улирлын павилионыг суманд байгуулан өгч, эзэмшлийг ногоочдын хоршоонд хариуцуулахаар анхан шатны хоршоо байгуулах төслийн сургалтыг зохион байгуулж 32 хүнийг хамруулан ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 09 дүгээр сард “Бороо гоулд”, Ерөнхий боловсролын сургууль, “Тулга энх”, “Кристал топ майнинг”, “Гэгээнцолмон” зэрэг аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж нийт 10 иргэнийг байнгын, 14 иргэнийг түр ажлын байраар хангасан.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж байнгын асаргааны мөнгөн тэтгэмжинд 4 иргэнийг, 2 иргэнийг тэжээгчээ алдсаны тэтгэмжинд, 1 иргэнийг хорихоос суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй иргэнийг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжинд хамруулахаар шийдвэрлэсэн.

2020 онд сумын Орон нутгийн орлогын жилийн төлөвлөгөө 190.7 сая төгрөг бөгөөд эхний 09 дүгээр сарын байдлаар 114.7 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс ХБГ-ээр 185.4 сая төгрөг буюу 161.6 хувийн биелэлттэй байна. Аймгийн санхүүгийн дэмжлэгээр 441.7 сая төгрөгийн санхүүжилтийг авсан.

Төсвийн байгууллагуудын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн 100 хувь олгосон, хугацаа хэтэрсэн өглөг, авлага үүсгээгүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 5 ажил хийхээр төлөвлөснөөс 4 ажил 100 хувь, 1 ажил 80 хувийн биелэлттэй байна.

Нийгмийн даатгалын санд нийт 59,8 сая төгрөгийн орлого орж Сэлэнгэ аймаг нийгмийн даатгалын хэлтсээс 328,2 сая төгрөгийн санхүүжилт авч 3 төрлийн тэтгэвэрт нийт 328,2 сая төгрөгийг 917 иргэнд олгосон. Хөдөлмөрийн чадвар түр алдалтанд 4 хүнд 1,2 сая төгрөг, жирэмсэн амаржсан 2 хүнд 3,4 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 1 хүнд 1,0 сая төгрөгийг тус тус олгосон.

### **Ерөө сум:**

Амьжиргаа дэмжих зөвлөлийн 2 удаагийн хурлаар нийгмийн халамжийн 3 төрлийн үйлчилгээнд 10 иргэнийг хамруулах тухай шийдвэр гаргаж, доорхи үйлчилгээнд хамрууллаа. Үүнд:

- Онцгой тохиолдлын тэтгэмж 1
- Нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж – ахмад настны асаргаа 5

- ХБИ-ний асаргаа 2, хүүхдийн асаргаа 1
- Хүндэт донор ахмад настан түлшний хөнгөлөлт олгох 1 иргэн хамрагдлаа.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 27 өрхийн 158 иргэнд 8, 9-р сарын хүнсний барааны олголт хийж, үйлчилгээнд насанд хүрсэн 70 иргэн, 88 хүүхэд хамрагдаж, 7,296,0000 төгрөгийн санхүүжилт шилжүүлэн ажиллалаа.

Нийгмийн халамжийн үйлчилгээ цахимд шилжих ажлын хүрээнд иргэдийн мэдээллийг шинэжлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавьж, зээл төлөлтийн графикийг зээлдэгч нэг бүр дээр хяналт тавьж, хугацаа хэтэрсэн 2011-2016 оны зээлийг төлүүлэхээр сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаа хэтэрсэн 9 иргэнтэй эргэн төлөлтийг төлүүлэх тал дээр анхаарч хугацаатай мэдэгдэл өгч ажиллалаа. Үр дүнд 09-р сард сум хөгжүүлэх сангийн 100130255401 тоот дансанд 32,0 саятөгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлж ажиллалаа.

Төсвийн болон орон нутаг, хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Бугант худалдааны төв, цагдаагийн байрыг цэвэр бохир, халаалтын нэгдсэн шугамд холбох 17000,0 мянган төгрөгийн өртөгтэй ажилд “Уран төмөр хэлхээ” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллалаа.
2. Буурагчин багт гудамжны гэрэлтүүлэг хийх ажилд 15750.8 мянган төгрөгөөр “Уран төмөр хэлхээ” ХХК гэрээ байгуулж ажлыг 100 хувь гүйцэтгэн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хүлээлгэн өгсөн.

ДЗОУБ-аас 2020 онд шинээр 1-р ангид элсэн суралцаж буй 54 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, цүнхний дэмжлэг үзүүллээ.

1-р багийн иргэн Б.Ууганбатын гэрт гал түймэр гарч гарз хохирол учирсан тул сумын “Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөл”-ийн гишүүд 265,000 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг үзүүлж ажиллалаа.

Сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2 аж ахуйн нэгж байгууллагад сумын Засаг даргын 2 удаагийн захирамжаар цэвэрлэх байгууламж болон ашигт малтмал ашиглах зориулалтаар нийт 265.47 га газрыг ашиглуулахаар, мөн 1 аж ахуйн нэгж байгууллагад 23.5 га газрыг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний засварын газрын зориулалтаар эзэмшүүлэхээр тус тус шийдвэрлэсэн. Мөн Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавих, тооллого явуулах ажлын хүрээнд Гр-047, Рр-104, Тп-855, ГЦТ-5259, ГЦТ-5253, ГЦТ-4129, ГЦТ-806, ГЦТ-113, ГЦТ-731 цэгүүдийн байршлыг тогтоон хяналт тавиж ажиллалаа.

*Хууль, эрх зүй, сургалт сурталчилгааны ажлын хүрээнд:*

- Хамтарсан багийн гишүүдэд “Хамтарсан багийн хууль дүрэм, журам”, “Хүүхдийн эрх, хүүхдийн хүчирхийллийн хэлбэр”-ийн талаарх сургалт зохион байгуулж ажиллалаа.
- Иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг олон нийтэд сурталчилах, холбогдох зөвлөмжөөр хангаж ажиллалаа.
- Татварын хэлтсээс татвар төлөгчдөд зориулсан заавар зөвлөмжүүдийг сумын файсбүүк цахим хаягаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

- ДЗОУБ-аас “Хүүхэд хамгааллын бодлого” сэдэвт сургалтыг зорилтот өрхийн 10 эцэг эхэд зохион байгуулж ажиллалаа.

Намрын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан 1,2 -р багийн 50 гаруй малчин өрхөд “Ойн тухай” хууль болон “Ой хээрт явахдаа дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа” хялбаршуулсан гарын авлага тарааж, малчин өрх бүрийг үнс нурмаа аюулгүй хадгалах таглаа бүхий савтай болох үүрэг өгч ажилласан. Мөн болзошгүй түймрийн үед иргэнийхээ үүргийг биелүүлж гарсан түймрийг унтраах, сум орон нутгийн удирдлагуудад мэдээллийг цаг алдалгүй дамжуулах, талаар хэлж анхааруулж ажиллалаа.

Цэцэрлэгийн эрхлэгч, аргазүйч нар сумын 1, 2-р багийн засаг дарга нартай хамтран Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдвал зохих 2-6 хүртэлх насны 373 хүүхдүүдийн судалгааг нэгтгэн гаргалаа. Үүнд:

№	Хамрагдсан бүлэг	Нас	Хүүхдийн тоо
01	Бэлтгэл “А” бүлэг	5	39
02	Бэлтгэл “Б” бүлэг	5	39
03	Ахлах “А” бүлэг	4	32
04	Ахлах “Б” бүлэг	4	31
05	Дунд бүлэг	3	35
06	Бага бүлэг	2	30
	НИЙТ		206

Үүнээс:

- Халамж эдэлдэг-3 /5 настай -1 эр, 4 настай 2, эр-1, эм-1/
- Хөгжлийн бэрхшээлтэй байхгүй
- Малчны -20 /эр-19, эм-1/

1-р цэцэрлэг хүүхдийн ундын усны эрүүл ахуйг сайжруулах үүднээс 750,000 төгрөгийн хөрөнгөөр шинээр худаг гаргалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилийн статистик үзүүлэлт:

- Нийт суралцагч 758, бага ангийн сурагч 390, дунд ангийн сурагч 255, ахлах ангийн сурагч 113
- Удирдах ажилтан 4, нийт багш 40, ажилтан 19 бүрэлдэхүүнтэйгээр сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.

БШУЯ-ны 2020 оны 6/1071 тоот “Аян зохион байгуулах тухай” албан бичгийн хүрээнд “Төрийн дууллаа хүндэтгэн дуулж, төрт ёсоо дээдэлье” аян зохион байгуулж, “Төрийн дууллаа хүндэтгэн дуулж, төрт ёсоо дээдэлье” мэдээллийн самбар гаргаж сурагчдад “Монгол улсын төрийн дуулал” тухай мэдээллийг гарын авлага болгон тарааж ажиллалаа.

Ерөө суманд 960 хүүхдийн багтаамжтай сургуулийн шав тавих ёслол болж, БСУ-ын сайд Л.Цэдэвсүрэн, “Монголын алт (МАК)” ХХК-ий бодлогын зөвлөлийн дарга Б.Нямтайшир, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа болон сургуулийн хамт олон, гүйцэтгэгч болон хөрөнгө оруулагч компаний төлөөлөл оролцлоо.

Тус үйл ажиллагааг угтан суралцагчдын дунд “Дахин ашиглая, ахин хэрэглэе”, “Идэвхтэй хөдөлгөөн”, “Миний мөрөөдлийн сургууль” гэсэн 3 төрлийн уралдааныг зохион байгуулж шалгарсан суралцагчдыг “МАК” компаний зүгээс

“Найрамдал” зусланд амрах эрхээр 30 сурагчийг, гар утсаар 3 сурагчийг, зөөврийн компьютерээр ахлах ангийн 3 сурагчийг тус тус шагнаж урамшууллаа.

ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар хийгдэж буй дотуур байрны ариун цэврийн байгууламжийн барилгын ажил эхэлж, мөн байгууллагын 48 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн гүний худаг ашиглалтад ороход бэлэн болоод байна.

Монгол Улсын Засгийн Газрын санаачлагаар Соёлын яам, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас хамтран зохион байгуулсан “Соёлын цаг” аяны хүрээнд Монгол хэл бичиг, соёлын өвийг хамгаалах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, эх хэл түүх ёс заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээлэлийг түмэнд түгээх зорилгоор Ерөө бүсийн Соёлын ажилтануудын дунд зохион явуулж буй “Эх хэл-Соёлын дархлаа” арга хэмжээг зохион байгуулагдлаа. Мөн номын сангаас “Эх хэл- Соёлын дархлаа” аяны хүрээнд үнэт ховор ном, эх хэлний холбогдолтой ном, шинэ номын үзэсгэлэн, Орон нутаг судлах танхимаас Бичиг соёлын түр үзэсгэлэн тус тус гаргаж иргэдэд сурталчилж ажиллалаа.

Төвлөрсөн хогийн цэгийг түрж цэгцлэх ажил хийгдэж, орон нутгийн төсвийн хог хаягдлын зардлаас 1,500,000 мянган төгрөгийг зарцуулж ажиллалаа.

#### **Ургац хураалтын мэдээ:**

- Ангилсан талбай 1656 га-аас цайруулсан 1001 га нийт ургац 120212 тн га-ийн ургац 12 цн байна.
- Шууд хураасан 1058 га-аас 13754 тн га-ийн ургац 13 цн хураан аваад байна.

Мишээл Экспо худалдааны төвд зохион байгуулагдсан “Намрын ногоон өдөр”-үүд үзэсгэлэн худалдаанд Ерөө сумын 5 ногоочин оролцож, 8 төрлийн төмс, хүнсний ногоогоор 7,466,200 төгрөгийн борлуулалт хийсэн.

Азийн хөгжлийн банкнаас ХХААХҮЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуйг эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 91-92 мон” төслийн хөрөнгө оруулалтын нэг болох “Өвлийн хүлэмж”-ний суурь цутгалтын ажил хийгдлээ.

#### **Жавхлант сум:**

Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 4 удаа хуралдлаа.

Аймгийн Засаг даргын захирамж 4, Засаг даргын захирамж 6, Засаг даргын албан тоот 12, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 1, Засаг даргын Тамгын газрын даргын албан тоот 8 гарсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, 1-р Цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн шинэ жилийн нээлтийг онцгой дэглэмийн үед авч хэрэгжүүлэх тушаал журмыг чанд мөрдөн биелүүлж сурагчдаа хүлээн авч хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүллээ.

Сумын Засаг даргын 2020 оны “Хяналт шалгалт хийх” удирдамжаар дагуу сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 4-н аж ахуйн нэгжийн хүнсний дэлгүүр, ЕБС-ийн үдийн цайны гал тогоо, дотуур байрны гал тогоо, 1-р цэцэрлэгийн гал тогоо, цайны газарт хяналт шалгалтыг хийж ажиллалаа.

Орон нутгийн сонгууль болохтой холбогдуулан сумын сонгуулийн салбар хороо байгуулагдан ажиллаж байна.

2020 оны А\17 тоот тушаалаар батлагдсан цэцэрлэг, сургуулийн хичээл, сургалтыг зохион байгуулахад мөрдөх түр журмын холбогдох заалтуудыг

сургалтын хөтөлбөр болгон боловсруулж бага, дунд, ахлах ангийнханд тохирсон хэлбэрт оруулан сургалт зохион байгууллаа. Үүнд нийт 12 багш 160 сурагчид хамрагдлаа.

1 дүгээр цэцэрлэг нь коронавируст халдварын цар тахлаас хамаарсан онцгой нөхцөл байдалд 2020-2021 оны хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагааг эхэлж байгаатай холбогдуулан сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах түр журмыг боловсруулан мөрдөж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/140 дүгээр тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж”-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулан, телехичээлийг бататгах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 3-5 настай 80 хүүхдийг хүлээн авах бэлтгэл ажлыг бүрэн ханган, халдвараас сэргийлэх, халдваргүйжүүлэлт, ариутгалын бодисын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор ДЗОУБ-аас 3 бүлгийн хүүхдүүдэд гар ариутгагч, хичээлийн хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлсэн.

“Мөнх-Ариун Сэлэнгэ” ХХК-иар байгууллага болон эргэн тойрны 540 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж, хүүхдийн хоол, хүнсэнд хэрэглэгдэх ундны усны дээжийг МХГ-т хүргүүлэн ажиллалаа.

Тухайн сард 233 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж зөвөлгөө өгч ажиллалаа.

- Амбулаторийн үзлэгээр- 78
- Урьдчилан сэргийлэх үзлэг -120
- Идэвхитэй хяналтаар - 10
- Гэрийн идэвхитэй эргэлтээр- 25
- Холын дуудлага- 12, ойрын дуудлага 14 хүлээн авч хугацаа алдалгүй тусламж үйлчилгээг үзүүлсэнээр иргэдээс санал гомдол гараагүй байна.

ЗГХЭГ, Соёл урлагийн газрын даргын А/43 тоот тушаалын дагуу “Соёлын цаг” соёл, нөлөөллийн аянг зохион байгуулах төлөвлөгөө гарган “Бидний хүч хамтын оролцоо” бүтээлч баг шалгаруулах аянаар 1.200.000 төгрөгний тохижилт, мэдээллийн самбаруудыг шинэчиллээ.

“Хот айлын соёлын хөгжил” аян гэр сургалт, СББА-Ө-ийн үзэсгэлэн, “Нар дагуулсан намрын өдрүүд” явган аялал зохион байгуулагдлаа.

Ерөө бүсийн “Эх хэл соёлын дархлаа” өдөрлөг, урлаг, спортын арга хэмжээнд “ Орон нутгийн соёл урлагийн өнөөгийн байдал, угсаатны хэл аялгуу, цаашид хэрэгжүүлэх арга зам” илтгэлийн уралдаан, урлагийн мэндчилгээний төрөлд тэргүн байр, гар бөмбөг, ОНТС-ын үзмэр, хөгжилтэй буухиа тэмцээнд дэд байр, номын сангийн үзэсгэлэнгээр 3-р байранд шалгаран нийлбэр оноогоор “Тэргүүн” байранд шалгарсан амжилт үзүүллээ.

Номын баяр-2020” “Хязгаар үгүй-НОМ- сэтгэлгээний эрх чөлөө” өдөрлөг зохион байгуулагдан “Бидний хайртай ном” үзэсгэлэн, “Налгархан намар” зохион бичлэгийн уралдаан, “Үлгэр ярих цаг”, “Таны бэлэг номын өргөөнд” номын хандиваар 32 ш номоор фонд баяжилтаа нэмэгдүүллээ.

Орон нутгийн татварын орлогын 08 сарын төлөвлөгөө 28660,7 мянган төгрөгийн орохоос 34218,1 мянган төгрөг орж 119,3 хувийн биелэлттэй байна.

ОНХСангийн хөрөнгөөр хийхээр төлөвлөгдсөн “Халуун усны барилга засвар”-ын ажлын тендер зарлагдаж амжилтгүй болж, уг ажлын тендерийг дахин

зарлахаар төлөвлөөд байна. Мөн сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн цайны тендерийг цахимаар хэлбэрээр зарлан ажиллаж байна.

Аймгийн төрийн аудитын газраас 2019 оны ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдалд хянал шалгалтыг хийсэн.

Аймгийн ИТХ-аар төсвийн тодотгол хэлэлцэхтэй холбогдуулан шаардлагатай төсвийн тооцоог хийж аймгийн СТСХ-т хүргэж ажиллалаа.

Сумын хэмжээнд улаан буудай 8410 га, тосны ургамал 2030 га, малын тэжээл 185 га, төмс, хүнсний ногоо 210 га талбайд тариалалт хийсэн. 9-р сарын 23-ны өдрийн байдлаар улаан буудай шууд хураалтаар 520 га талбайгаас 490 тн ургац хурааж 635 га ангилан хадалт, тосны ургамал 1910 га талбайг ангилан хадалт, тэжээлийн ургамал 182 тн, төмс, хүнсний ногоо 54 га талбайгаас 730 тн ургац тус тус хураан аваад байна.

Улаанбаатар хотноо жил бүр зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд тус сумын 2 иргэн амжилттай оролцлоо.

2020-2021 оны өвөлжилт, хаваржилтийг өнөтэй давах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчин, мал бүхий 421 өрхөд уриалгыг бэлтгэн хүргүүлж, цахим орчинд мэдээ, мэдээлэл байршуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд нийт 1665 га талбайд 164 малчин мал бүхий иргэдтэй хадлан бэлтгэлийн гэрээ хийсэн.

### **Зүүнбүрэн сүм:**

Хамтарсан багийн гишүүдэд “Хүүхэд хамгаалал-Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд”, “Хүүхдийн эрх болон хүүхэд хамгааллын эрх зүйн асуудал”, “Хамтарсан багийн үйлчилгээний маягт, практик хэрэглээ арга зүй” сэдвээр тус тус сургалт зохион байгуулж цаашид хэрхэн ажиллах талаар санал солилцож ажиллалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны дэмжлэгэйгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын чанарын судалгааны Аир баг ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх олон нийтийн төслийн хэрээнд 4 иргэнд тус бүр 100.000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүллээ.

Шинэ хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан 1 дүгээр цэцэрлэгт 31 ажил хэрэгжүүлэхээр багш ажилчдын хурлаар хэлэлцэн батлаж хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа.

Сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааг хүүхдийн хөгжил, эрэлт хэрэгцээ, нас сэтгэхүйн онцлогт тохируулан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих арга зүйн зөвлөмжийн дагуу төлөвлөж өдрийн дэглэмийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд өдрийн ангид 510, дүйцсэн хөтөлбөрийн ангид 15 нийт 525 суралцагчтайгаар сургалтын үйл ажиллагааг эхлүүллээ. Сургуулийн дотуур байранд нийт 113 сурагчийг хүлээн авч урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрууллаа.

“Номын баярын өдөр”-ийг “Хязгаар үгүй ном–Сэтгэлгээний эрх чөлөө” уриан дор зохион байгуулж, мэдээллийн булан байгуулан “Өглөгийн дээд ном” хуучин номын хандивын аян, “Манай гэр бүлийн номын сан” фото зургийн уралдааныг тус тус зохион байгуулж ажиллалаа.

“Төрийн дууллаа хүндэтгэн дуулъя” арга хэмжээнийн хүрээнд анги бүр 1-р цагийн хичээлийг төрийн дуулалаар эхлүүлж байна.

Эрүүл мэндийн төв нь

- Амбулатороор 145 иргэнд үзлэг
- Урьдчилан сэргийлэх үзлэгээр 176
- Диспансерийн хяналтаар 14
- Гэрийн идэвхтэй эргэлтээр 6
- Дуудлагаар 30 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ.

Улаан буудай 1740 га-с 2993 тн, төмс 60 га-с 590 тн, хүнсний ногоо 270,98 га-с 1980,03 тн тус тус хураан аваад байна.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас жил бүр зохион байгууладаг “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээний “Алтан намар 2020” үзэсгэлэн худалдаанд 12 иргэн 26,7 тн төмс, хүнсний ногоогоор оролцож “Шилдэг зохион байгуулалттай сум”-аар шалгарсан амжилтыг үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх аймагт ирсэнтэй холбогдуулан зохион байгуулсан хүнсний ногооны үзэсгэлэнд 12 төрлийн хүнсний ногоо, шилмэл омгийн суманд үржүүлж буй Араб, Англи адуугаар оролцлоо.

“Иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт” аяны хүрээнд 3 багт морьт эргүүл ажиллуулж, ойн нөхөрлөлүүдтэй хамтран хяналт шалгалтыг зохион байгуулахад хууль бус зөрчил илрээгүй байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах тухай аймгийн онцгой комиссын 01 тоо албан даалгавар, аймгийн Засаг даргын А/94, сумын Засаг даргын А/54 тоот захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж 5 аж ахуйн нэгж, 120 иргэнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, гарын авлага материалаар ханган ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын Засаг даргын 2020 оны А/151 тоот захирамжийн дагуу малчин, мал бүхий 213 иргэн, 2 аж ахуй нэгж байгууллагатай 2500 га газарт байгалийн хадлан ашиглуулах гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. Хадлангийн газрын маргаантай 4 иргэний асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн мал эмнэлгийн газраас зохион байгуулсан Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциний аюулгүй байдлын сургалтанд хамрагдаж вакцинаа хүлээж авч “Оюут сүрэг”, “Энхбүрэн сүрэг” МЭҮН нь бод 2840 толгой, бог 18000 толгой төл малыг вакцинжуулалтанд бүрэн хамруулж дуусгалаа.

МЭҮН-н мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах, отор нүүдэл хийх болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үеийн мал эмнэлгийн гарал үүслийн цахим гэрчилгээг 2709 кг мал, амьтны мах, 190 толгой мал, 10,000 тн сүүнд олгож, нэгдсэн мэдээллийн сантай холбогдон баталгаажуулж ажиллалаа.

Сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтыг хянан шалгаж, Санхүүгийн удирдлагыг мэдээллээр хангах системд давхардсан тоогоор 1,130 байгууллагын 1,329,074,762 төгрөгийн гүйлгээг шивж орууллаа.

Сумын хэмжээнд 18,080,000 төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай, цалингаас суутгасан НДШ 1.443.945, НДШ 25.626, хоол 69,700 урсгал засвар 1.225.700, эмийн 11,049,717, нийт 13.814.688 төгрөгийн өглөгтэй байна.

### Мандал сум:

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан шинээр 4, сунгалт 4, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр 3, сунгалт 4, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шинээр 2, сунгалт 5, нийт 22 иргэний өргөдлийг шийдвэрлэж ажиллалаа. Халамжийн 6 төрлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор цахим хэлбэрт шилжүүлж, Халамжийн нэгдсэн системийг ашиглаж эхэллээ. Үүнд: Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж зэрэг нийт 1232 иргэний бүртгэлийг Ehalamj.mn системд хөрвүүлэн баталгаажуулан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 9 иргэнд “Тунгалаг аялгуу” ХХК-тай хамтран Сонсголын дижитал аппарат үнэ төлбөргүй хийлгэлээ.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг “Дөлгөөн мандал” хүнсний дэлгүүрээс зорилтот өрхийн 4 хүүхдэд хичээлийн хэрэгсэл цүнхийг хандивлалаа. Хүнсний талонд хамрагддаг өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор намрын ургац хураалтын ажилд цалинтай хамрууллаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн мэдээллийн дагуу 6 кейст хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэн 2 кейсийн асуудлыг шийдвэрлэж хаасан.

17 кейст хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнүүдийг нийт 53 иргэдэд үзүүлэн ажилласан.

№	Кейсийн ангилал	Кейсийн тоо	Хүүхдийн тоо	Насанд хүрэгчдийн тоо	Нийт тоо
1.	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн кейс	6	6	10	16
2.	Иргэдээс ирсэн кейс	1	2	4	6
3.	Цагдаагийн байгууллагаас ирсэн кейс	3	5	5	10
4.	Гэмт хэргийн хохирогч хүүхдийн байцаалтанд	4	5	2	7
5.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн байцаалт	1	2	1	3
6.	Түр хамгаалах байр	1	4	1	5
7.	Асрамж халамжийн үйлчилгээ	1	1	5	6
8.	Нийт	17	25	28	53

Хүүхдийн хөгжлийг дэмжих, дугуйлангийн нэр төрлөө нэмэгдүүлэх, багш ажилчдын нөөц боломжоо ашиглан хүүхдэд өөрийгөө хөгжүүлэх, авъяас чадвараа нээн илрүүлэх, хүүхдийн сонирхолд тулгуурлан хүүхдийн оролцоог хангах, хөгжүүлэх, олон хүүхдэд хүрч үйлчлэхийн тулд дугуйлангийн тоог нэмэгдүүлж нийт 7 төрлийн дугуйланд 87 хүүхэд хамрагдаж байна.

Нэршил /дугуйлан/	Хамрагдсан хүүхдийн тоо				Хүйс		Нийт
	3-6 нас	6-11 нас	11-14 нас	14-18 нас	Эр	Эм	

1.	Шатар	7	5	4		-	16	16
2.	Бүжиг		5	5	6	-	16	16
3.	Англи хэл		10	2	1	7	6	13
4.	Төгөлдөр хуур		3	6		1	8	9
5.	Уран зураг			15	10	6	19	25
6.	Хийл		2			-	2	2
7.	Уран нугаралт	2	4			-	6	6
Нийт		9	29	32	17	14	<b>73</b>	<b>87</b>

Тус сумын Сум Дундын Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Сүүдэр бүү тусга” арга хэмжээний хүрээнд Хурд хамтлагийн “Ган судас нь амьдрал тэтгэнэ” тоглолт зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд Хүүхдийн ордны дугуйлангийн сурагч У.Уянга “Нарны хаан хүүхдүүд” дууг амжилттай дуулж “Хүүхдийн Эсрэг Хүчирхийллийн аян”-ы үйл ажиллагааны утга учрыг нийтэд хүртээж, хүүхдийн дуу хоолой болж чадсан.

Мандал сумын Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Хичээл эхэллээ” арга хэмжээнд хамтран оролцож “Dancechallenge”-г эхлүүлэн өрнүүлж байна.

Залуусын оролцоог дэмжих чиглэлээр Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан Улаанбаатар дахь Сэлэнгэ аймгийн залуучуудын холбоо, Соёмбо хамтлаг, Хүүхдийн ордон хамтран сумын 18-35 насны залуусын хооронд дуут үдэш буюу “**Cover night**”-г зохион байгуулж 45 залуус хамрагдсан.

Хүүхдийн оролцооны чиглэлээр ДЗМОУБ-аас зохион байгуулсан “We tomorrow” цахим чуулга уулзалтад “Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клубын гишүүдийг хамруулах арга хэмжээг зохион байгуулж нийт 14 сурагчын <https://www.surveymonkey.com> аппликейшнаар явагдсан судалгаанд хамруулж өөрсдийн дуу хоолойг улсын хэмжээний чуулга уулзалтад хүргэж ажиллалаа.

- “СББ” ХХК-ий 300 айлын орон сууцны дундах тоглоомын талбайг иж бүрэн тохижуулж ашиглалтад орууллаа.
- Төмөр замын 1-р баг болон Баянхангайн 6-р багийн 3,7 км, Баянсуудалын 3-р багийн 0,5 км нийт 4,2 км авто замын хэвтээ тэмдэглэгээг хийж, 15 хурд сааруулагч, 9 явган хүний гарцыг будаж, авто замын 4 хэсэгт “Хурд хас” санамжийг бичиж замын хөдөлгөөний тэмдэглэгээг сайжрууллаа.
- “Хэрх” соёлын төвийн барилгын засварын ажил эхэллээ.
- Төмөр замын 1-р багийн Вокзалын гудамжны асфальтан замын 2 талд авто замын хашлага хийх, явган хүний зам барих ажлыг эхлүүллээ.
- Засаг даргын тамгын газрын өргөтгөлийн барилгын дотор сантехник засвар, 1-р дахварын угтах хэсэг, 3-р давхарын хурлын заалны засварын ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.
- Сумын төвийн доторх хайрган хучилттай авто замуудыг засварлах ажлын гүйцэтгэл 30 хувьтай үргэлжилж байна.

Тус сар улаанбуудай 212 га-гаас 970 тн, малын ногоон тэжээл 135 га-гаас 315 тн, төмс 324 га-гаас 3410 тн, байцаа 181 га-гаас 2120 тн, лууван 125 га-гаас 1991 тн, шар манжин 25 га-гаас 319 тн, улаан манжин 16 га-гаас 196 тн, сонгино 21 га-гаас 251 тн, сармис 8 га-гаас 86 тн, өргөст хэмх 7 га-гаас 132 тн, улаан лооль 4

га-гаас 48 тн тус тус хураасан ба улаанбуудайн хураалт 20 хувь, төмс хүнсний ногооны хураалт 75 хувь явагдаж байна.

Хадлангийн талбай ашиглах гэрээг шинчлэх ажлыг явуулж 176 иргэний мэдээллийг шинэчлэн хувиарт 598,4 га газрыг олголоо. Хадлан бэлчээрийн маргааныг цаг тухай бүрт нь шийдвэрлэн хадлангийн талбайд намаржсан 25 малчин өрхөд мэдэгдэл хүргэж нүүлгэх арга хэмжээ авч ажиллалаа.

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд сумын хэмжээнд нийт Хурга 9800, Ишиг 10000, Тугал 7760 төл мал хамрагдсан байна.

Сумын Засаг даргын А/169 тоот захирамжийн дагуу хүнсний худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны үйл ажиллагаа явуулдаг 68 ААНБ-д хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг илрүүлэн зохих шаардлага, зөвлөмжийг өгч ажилласан.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт: Талбай тусгаарлалт хийлгэх 1 нөхөрлөл хүсэлт гаргасаны дагуу цэвэрлэгээний ажлаар 4 га талбайд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажил хийлээ. Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 4 ААНБ, 7 нөхөрлөлд 243 м3 хэрэглээ, 85 м3 түлээ олгож, гарал үүслийн гэрчилгээг хэрэглээ 522 м3, түлээ 107 м3 нийт 629 м3 бичиж олголоо.

2020 онд 1540 тн хуш модны самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэхээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарч 7 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 6 аж ахуйн нэгжид 245 тн самар үйлдвэрлэлийн зориулалалтаар, ахуйн зориулалтаар 17 иргэнд 425 кг-ыг бэлтгэх зөвшөөрөл олгож ажиллалаа.

Сумын Засаг даргын А/180 “Хуш модны самар бэлтгэх үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчил, болзошгүй аваар ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх захирамжийн хэрэгжилтийг хангаж Барчулуут, Түнхэлийн Хужиртын аманд Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран хяналтын пост ажиллуулж байна.

Сэлэнгэ аймаг Мандал сумын ИТХ-тай хамтран “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч”-ийн үр хүүхдүүдэд галын түлээ үнэгүй олгох үйл ажиллагааг зохион байгуулж 20 хүнд 20 мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагууд үнэгүй түлээ олгосон.

Мандал суманд ойн санг гэрээгээр эзэмшдэг мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагуудад “Мод бэлтгэл технологийн карт боловсруулж, технологийн дагуу мод бэлтгэл явуулах, хяналтын хуудсыг зөв ашиглах” чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 12 аж ахуй нэгж байгууллага хамрагдахаас 8 аж ахуй нэгж байгууллагуудын уулын мастерууд хамрагдсан.

### **Орхон сүм:**

Covid-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн цахим орчинд **Orkhon Sum Zdtg Selenge** Facebook хаяг /3.7к дагагчтай/, Орхон сум ЗДТГ/1.7к дагагчтай/, Сэлэнгэ аймаг Орхон сум групп /3.2к дагагчтай/, Нарт Орхоны хүүхдүүд/2.2к дагагчтай/, Selenge orhon Emt бүртгэлтэй хаягуудаар мэдээлэл, сурталчилгаа, зөвлөмж, Улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрүүдийг хүргэх ажлыг тогтмол зохион байгуулж байна. Монголын ахмадын баярыг угтан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Алтан намар үзэсгэлэн худалдаа өдөрболж өндөрлөлөө. Ахмадууд идэвхтэй оролцож сүү цагаан идээ, төрөл бүрийн хүнсний ногоо, халуун хоол, самар зэрэг бүтээгдэхүүнтэй оролцлоо.

2020 онд 4 өрхөд гал гарч хохирол учирсан тул орон нутгийн эрсдлийн үнэлгээг гаргуулах зайлшгүй шаардлага үүсч байгаатай аймгийн Онцгой байдлын газарт сумын өрхийн эрсдлийн үнэлгээг хийлгэж, хамтран ажиллахаар албан тоотыг хүргүүлэн ажиллалаа.

Шинээр ажлын байр бий болгосон 14 иргэнийг ажилд зуучлан ХХҮГ-т хүргүүлсэн.

Аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар сумын төвийн гүний худагт 15 сая төгрөгийн өртөгтэй ус зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулсан. “Цемент шохой” ХК-ий техникийн тусламжтайгаар сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг түрж багасгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн газраас “Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүс нутаг”-ийг тогтоохоор төлөвлөсөнтэй холбогдуулж сумын “Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх” бүс нутгийн саналыг боловсруулж сумын Засаг даргаар баталгаажуулж ажиллалаа. Сумын хэмжээнд 2020 оны өвөлжилтөнд зориулж малчин мал бүхий 330 өрхтэй 3513 га, бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэх хүсэлт гаргасан 155 иргэнтэй 7044 га талбайд хадлангийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын А/223 тоот, сумын Засаг даргын А/91 тоот захирамж дархлаажуулалт сумын хэмжээнд Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх мал амьтныг бүрэн хамруулах зорилгоор МЭТ, МЭҮН-д 2020 оны вакцины ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Бүрэн-Орхон” ХХК мал эмнэлэг нь 1320 тугал, 6300 хурга, 5870 ишиг вакцинд хамруулаад байна. “Эгдэм” БГБНХ мал эмнэлэг нь 1280 тугал, 5200 хурга, 5400 ишиг вакцинд хамруулаад байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн хийж нийт **27912646.25** төгрөгийн гүйлгээг хийсэн. Төсвийн гүйцэтгэлийн 08 сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулсан.

2020-2021 оны хичээлийн жилийн зорилго, зорилтоо багш нарын хурлаар хэлэлцэн баталж, мэргэжлийн багш нар 09-р сарын бататгал хичээлийн төлөвлөлтийг арга зүйн зөвлөмжийн дагуу боловсруулан сургалтын менежерээр батлуулж, Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрдүүлж, багш бүрийн тасралтгүй хөгжил, хамтын оролцоог дэмжих зорилго тавин ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан монгол хэлний багш нар хамтран монгол хэл, бичгийн соёлын өвийг хамгаалах, бахархах, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор цахим хичээл бэлтгэн I-XII ангийн сурагчдад зохион байгууллаа.

Сумандаа байнгын оршин суугаа 152 хүүхдээс 101 хүүхдийг 66.4 хувь, сумандаа оршин суудаг 186 ахмадаас 98 ахмадыг 52.6 хувьтай гэрийн эргэлт хяналтанд хамруулсан. Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээг хэвтрийн 3 өвчтөнд үзүүлсэн. Сумын Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн зөвлөлийн санаачлагаар “ХӨДӨЛГӨӨНӨӨР ЭРҮҮЛЖИЦГЭЭЕ” аяныг хамтран зохион байгуулж ажилласан.

ЭМГ-ын даргын А/40 тоот тушаал “СУВИЛАГЧ СОЛИЛЦОО” аяны хүрээнд ахлах сувилагч П.Мөнхцэцэг Сант сумын Эрүүл мэндийн туршлага солилцон ажиллалаа.

Сайхан сум дахь Гал түймэр унтраах, аврах 61-р ангиас зохион байгуулсан “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах” сэдэвт сургалтанд эмч, эмнэлгийн 16 ажилчид хамрагдаж гал түймэр гарсан үед хэрхэн ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл авч ажиллалаа.

### **Орхонтуул сум:**

Сумын ЗДТГ болон Рашаант тосгон нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлэн шилжин ажиллаж байна.

Сумын засаг даргын 2020 оны А/18 тоот захирамжаар сумын хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, орон нутагт үйлдэгдэж байгаа зам тээврийн осол, хэрэг, зөрчлийг арилгах зорилгоор “Орон нутгийн зам-Хөдөлгөөн соёл” аяны хүрээнд “Яараад яахав дээ” аяны хүрээнд сумын иргэдэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үзүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 4 хүүхдэд хүндэтгэл үзүүлж ажиллалаа.

09-р сард Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 4394.9 мян төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 679.4 мян төгрөгийн орлого төвлөрүүлж ажиллалаа. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд иргэдийг 3 иргэнийг шинээр хамрууллаа.

Өндөр насны тэтгэвэрт 155320.5 мян.төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 45382.1 мян.төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 7350.0 мян.төгрөг, цэргийн өндөр насны тэтгэвэрт 2289.4 мян.төгрөг, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1 хүн 458.0 мян.төгрөг нийт 543 тэтгэвэр авагчдад 211343.0 мян.төгрөгийг олгож ажиллалаа.

Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Гэр бүл хүүхэд залуучуудын салбарын хүний нөөцийг чадавхжуулах” сургалтад хамрагдсан.

Шинэ төрлийн Коронавирусын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжүүдийг иргэд, төр төсвийн байгууллагууд, аж ахуй нэгжүүдэд цаг алдалгүй цахим болон цаасан хэлбэрээр тасралтгүй хүргэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/98 тоот захирамжийн дагуу төл малыг бруцуллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад тугал 4200, хурга 28400, ишиг 21600 нийт 54200 толгой төл малыг хамруулсан.

Сумын орон нутгийн сангийн хөрөнгөөр хийгдэх Баянцогт 2-р багт 50 тн багтаамж бүхий зоорь барих /45,3 сая төгрөг/, Рашаант тосгонд явган хүний зам тавих /200 метр 15,0 сая төгрөг/-ийн ажлуудын тендерийг зарлан цахим хэлбэрээр байршуулсан.

09-р сард тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллага, төсөвт байгууллагуудын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 34,622,466 төгрөгийн төлбөр тооцоог, анхан шатны бичиг баримтыг үндэслэн 34 ширхэг төлбөрийн хүсэлтээр 51 удаагийн хандалтаар ЗГУМС-д гүйлгээг шивж баталгаажуулж ажиллалаа.

### **Сайхан сүм:**

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан даалгавар, захирамжийн дагуу төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд уг төлөвлөгөөний дагуу сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагаа эхлүүлэх бэлтгэл бэлэн байдалд хяналт шалгалт явуулсан. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал байхгүй. 3-р цэцэрлэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сантехникийн их засварын ажил хийгдэж байгаа бөгөөд хөрөнгө оруулалт царцсаны улмаас сургалтын үйл ажиллагаа түр хойшлон засварын ажлыг түргэвчилэн, бүрэн хийж дуусгахаар ажиллаж байна.

Коронавируст халдварт, /Covid-19/ цар тахлын аюулын бэлэн байдлын нөөцийг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын гар угаах нөхцлийг нэмэгдүүлэх зорилгоор сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.426.000 төгрөгөөр санитол 100 ширхэг, хамгаалалтын хувцас 60 ширхэг, халуун хэмжигч 11 ширхэг, маск 10.000 ширхэг, жавелин 8 хайрцагийг нийлүүлж байгууллагуудын бэлэн байдлыг хангахад туслалцаа үзүүлж ажиллалаа.

2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн 01/560 албан тоотын дагуу тус суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүр, зоогийн газруудад “Шинэ тиэн ди” ХХК-ий БНХАУ-ын “Өвөр Монголын Да Яо ундаа” ХХК-иас импортолсон жимсний амтат ундаа худалдан борлуулж байгаа эсэхэд хяналт шалгалт хийн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолыг үндэслэн Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/211 дүгээр тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу тус сумаас 6 залуучууд цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтад 10 хоногийн хугацаанд хамрагдав.

БОАЖГ-ын 434 албан тоотын дагуу аймгийн хэмжээнд “ХОГГҮЙ ЦЭВЭРХЭН МОНГОЛ АЯН”-ыг өрнүүлж байна. Уг аяны хүрээнд “Хоггүй цэвэрхэн сум болцгооё” удирдамжийн хүрээнд төлөвлөгөө боловсруулж, аж ахуйн нэгж, иргэдэд мэдээлэл хүргэн, “**Хог хаягдлын тухай хууль**”-иар гарын авлага бэлтгэн сурталчилж ажиллалаа.

Сайхан сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэгж нь тайлангийн хугацаанд нийт 86 мэдүүлэг, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 143 мэдүүлэг хүлээн авч холбогдох ажил үйлчилгээг явуулан улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийн дансанд 613,000 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдснаас оруулсан татварын орлогод 5,040,000 төгрөг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтийг хангуулахаар сум дундын Цагдаагийн хэлтэс болон Прокурорын газартай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 удаа, иргэний гомдол, мэдээллийн дагуу хяналт шалгалтыг 1 удаа тус тус зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар эрх

бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлий ашигласан 2 иргэнд, зөвшөөрөлгүйгээр дур мэдэн алт олборлосон 1 ААНБ, зөвшөөрөлгүйгээр самар түүж, тээвэрлэлт хийсэн 1 иргэнд тус тус “Зөрчлийн тухай хууль”-иар нийт 1.100.000 төгрөгийн торгуулын арга хэмжээ авч, 1 ААНБ-ын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон болно.

Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн байгууллага болох “Хэт-Жолоо” ХХК-ий нийт 129 м3 мод модон материал тээвэрлэлтэд 4 ширхэг гарал үүслийн гэрчилгээний бичилт хийж, Баруунбүрэн сумын ойн сан ашигласны төлбөрт 612.000 төгрөгийг байршуулсан. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй ойн дагалт баялаг ашигласан 1 иргэний 6 шуудай 120 кг самарыг хураан авч улсын орлого болгосон байна.

Энэ онд сумын хэмжээнд 28 ААН, 15 иргэн нийт 15547 га-д тариалалт хийснээс үр тарианы талбайд улаан буудай 12699 га, тэжээлийн ургамал 886 га, рапс 1361 га, овъёос 120 га, арвай 20, вандуй 10, төмс хүнсний ногоо 5 ААН, 65 иргэн нийт 549 га буюу төмс 280 га, хүнсний ногоо 269 га, царгас 12 га тариалсан байна. Улаан буудай 12699 га-гаас 15873,7 тн буюу 12.5 цн, рапс 1361 га-аас 1238,5 тн ба 9,1 цн, төмс 280 га-аас 3600 тн, хүнсний ногоо 169 га-аас 1859 тн ургац хураан авч, 7500 га ангилан хадалт, бусад 120 га талбайгаас 140 тонн улаанбуудай хураан авсан байна. Сайхан умын хэмжээнд ургац хураалт 68 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Сумын малчдаас 2020 онд ноосны урамшуулалд хамрагдах нийт 123 иргэний 126 ноосны урамшуулалд хамрагдах материалыг бүрдүүлэн холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. Иргэд нийт 37040 кг хонины ноос бэлтгэн тушааснаас 29782 кг нь чанарын шаардлагад нийцэн урамшуулалд хамрагдсан.

Хадлангийн талбайн ашиглалтыг зохицуулах тухай сумын Засаг даргын А/182 тоот захирамжийн нийт 180 иргэн өргөдөл өгснөөс 127 иргэн буюу 70,5 хувьнь гэрээ хийж 5500 га хадлангийн талбай олгогдож, орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын А/223, сумын Засаг даргын А/186 тоот захирамжийн дагуу Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Сумын хэмжээнд нийт 3160 тугал, 24800 охин хурга ишиг төлөвлөж, түүнээс 3095 тугал, 26595 хурга, ишгийг дархлаажуулалтанд хамруулан ажиллалаа.

Сайхан сумын Номгон 3-р багт оршин суугчийн хашаатай хонинд аянга бууж, 2 хонь 22 ямаа үхсэн байхыг булж, ариутгал халдваргүйтэлийг хийж ажиллалаа.

Тус сард төсвийн байгууллагуудын төсвийн хуваарлалтын дагуу санхүүжилт олгогдож сарын төлбөр тооцооны 2348 ширхэг баримтаар 5,430,376,707.45 төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Сайхан сумын хэмжээнд төр төсвийн байгууллага болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, татварын орлогын биелэлт, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг сар бүрийн 8-ны дотор Shilendans.gov.mn-д бүртгэн нийтэд ил тод болгон ажиллаж байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралт Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын дагуу зээл авах хүсэлтэй иргэдийн 30 гаргуй төслөөс сонгон шалгаруулж, нийт 20

иргэний төсөл хэлэлцэн батлагдаж 85.000.000 төгрөгийн зээл гаргахаар шийдвэрлэж, 17 иргэний 70.500.000 зээлийн гүйлгээ бүрэн хийгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсэгт хугацаа хэтрэлтэй 8 иргэний зээлдэгчийн хувийн хэргийн бүрдэлтийг мөн хаяг дээрээ байгаа үгүйг шалган ажиллаж байна.

Сайн дурын нийгмийн даатгалд 13 иргэн хамрагдаж, нийтдээ 402 иргэн 733.041.944 төгрөг, эрүүл мэндийн даатгалд 183 иргэний 9.766.720 төгрөг төвлөрсөн байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 1/1127 тоот албан бичиг, Сэлэнгэ аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын даргын 2020 оны 01/180 тоот албан бичгийн дагуу иргэнд газар өмчлүүлэх тухай Засаг даргын захирамж, шийдвэрийг түр хугацаагаар зогсоосон. 09-р сард нийт 12 өргөдөл, гомдол ирснээс 10 шийдвэрлэж ажиллалаа.

2020-2021 оны хичээлийн жилд Сайхан 1-р сургууль нь 54 багш, 26 ажилтан, 1082 сурагцагчтайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

2020-2021 оны хичээлийн жилд 1-р ангийн 3 бүлэгт 109 сурагч суралцаж байгаа бөгөөд 9 сарын эхний 3 долоо хоногт бэлтгэл хөтөлбөрийн 60 цагийн хичээл дараах ажиллагаа орсон.

Сурагчдын сурлагын чанарт анхааран, сурагчдын ном унших хүсэл сонирхлыг төрүүлэх, номтой нөхөрлүүлэх, эерэг хандлагыг бий болгох, номын өв санг арвижуулах, ном солилцох зорилгоор “Номын баярын өдөр” арга хэмжээг зохион байгуулж нийт сурагчид, багш, эцэг эхчүүдийг хамруулан ажиллалаа.

БСУГ-аас өдрүүдэд онлайн хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 54 багш 9 чиглэлээр хамрагдаж хичээл сургалтын үйл ажиллагааг хэрхэн зохион явуулах талаар мэдээллийг авч, сургалтын менежерүүд хариуцсан тэнхимийн багш нарт “Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх”, “Теле хичээлийн үр дүн”, “Танхимын бус сургалтын зохион байгуулалт”, “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагаа, эхлүүлэхэд анхаарах асуудал”, “Онцгой байдлын үеийн сургалтад хүүхэд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх” гэсэн сэдвийн хүрээнд сургалтуудыг зохион явууллаа.

Анги удидсан багш нар болон мэргэжлийн багш нар өндөржүүлсэн бэлэн байдлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус сургууль нь 2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр “Миний шидэт ертөнц” төслийг Канад сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Энэ төслийн хэрэгжилт болон сургуулийн үйл ажиллагаатай танилцахаар Канад улсын элчин сайд тус сургуульд айлчилсан.

Өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм, дэгийн талаар зөвлөмж боловсруулан сургуулийн нийт багш, ажилчдад таниулах, суралцагч, эхчүүдэд цахимаар, онлайнаар тус тус танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

12-р ангийн сурагчидтай мэргэжил сонголт, өглөөний хэвшил, өдрийн бүтээмж, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл гэсэн ерөнхий 4 чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн “Дэлхийн зөн ОУБ”-д хүсэлт гаргаж амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн 30 суралцагчдад цүнх, хичээлийн хэрэглэл хандивлав.

1,2,3-р цэцэрлэг нь 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагаагаа эхлүүлэн байгууллагын ажил хэвийн хангагдан явагдаж байна.

Шинэ хичээлийн жилд 2-р цэцэрлэгт 3-5 насны 165 хүүхэд бүртгэгдэн эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамрагдсаны гадна 9-р сарын 21-ний өдрөөс 2 настай 39 хүүхэд бүртгэгдэн цэцэрлэгт хамрагдаж эхлээд байна.

Өнөөдрийн байдлаар бэлтгэл бүлэг 1, ахлах бүлэг 2, дунд бүлэг 2, бага бүлэг 1 нийт 6 бүлэгт өдөр дунджаар 190 хүүхэд хүлээн авч, сургалт хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулагдаж байна.

Шинэ хичээлийн жилд хүүхэд хүлээн авах бэлтгэл ажил бүрэн хангагдсан бөгөөд өвлийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн дотор халаалт, цэвэр усны их засварын ажлыг хүлээн авч, үйл ажиллагаа доголдолгүй ажиллаж байна.

Сумын шуурхай штабаас гаргасан хуваарийн дагуу сургууль, цэцэрлэгийн нийт багш, ажилтнууд 1, 2-р багийн нутаг дэвсгэрт олон нийтийн эргүүл, хяналтын үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Сайхан сумын боловсролын байгууллагын багш ажилчдыг Сэлэнгэ аймгийн ЭМГ, БСУГ-ын хамтран баталсан удирдамжийн хүрээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулж, 257 багш ажилчид хамрагдахаас 246 багш ажилчид буюу 89,4 хувьтай хамрагдсан байна. Үүнээс эрүүл 149, өвчтэй 97 багш ажилчид гарч өвчлөлийн хувь 39,4 хувь байна.

Хөтөл Сум дундын эмнэлэг нь амбулаторийн тасгаар ерөнхий мэргэжлийн сувилахуйн тусламжийг давхардсан тоогоор 587 хүнд үзүүлсэн байна

- Амбулаторийн боолт 73 хүн / давхардсан тоогоор 213/
- Амбулаторийн тариа 144 /давхардсан тоогоор 318 /
- Урьдчилан сэргийлэх тарилга 56 хүүхэд хамрагдсан
- Хэвтэн эмчлүүлэх тасгаар ерөнхий мэргэжлийн сувилахуйн тусламжийг 41 хүнд давхардсан тоогоор 248 удаа үзүүлсэн
- Хэвтэн эмчлүүлэх тасагт төрөлжсөн сувилахуйн тусламжийг 29 хүнд үзүүлсэн
- Хүлээн авах яаралтай тусламжийн тасгаар 18 хүнд ерөнхий болон төрөлжсөн сувилахуйн тусламж үзүүлсэн
- Сувилахуйн гэрийн асаргаа сувилгааны чиглэлээр 6 хүнд нөхөн сэргээх болон сэргээн засах эмчилгээ хийж ажиллалаа.

Хичээл сургууль эхэлсэнтэй холбоотой ЕБ-ийн 1,2-р сургуулийн нийт 99 сурагчдад “Ковид 19”-ын халдвараас урьдчилан сэргийлээ” сэдэвт сургалт мэдээлэл хийж “Сурагчдад зориулав”, “Эцэг эхчүүдэд зориулав” 2 төрлийн 220 ширхэг зөвлөмж бүхий гарын авлагыг тарааж, сурагчдын эрүүл мэндийг дэмжиж хүүхэд бүрт витамин С, 50 мл-тэй гар ариутгагч санитол өгсөн.

Соёл Урлагийн газрын даргын 2020 оны А/43 тоот тушаал, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/251 тоот захирамжийн дагуу орон нутгийн иргэдэд Соёл урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Соёлын цаг” нөлөөллийн аяны хүрээнд, “Намар цагийн Соёл хүмүүжлийн нээлт”-ийн үйл ажиллагааг тус тус зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу Соёлын ордны уран бүтээлчдийн Задгай талбайн тоглолт, Номын сангийн шинэ номын танилцуулга, Орон нутаг сурталчлах танхимын ховор нандин үзмэрийг дэлгэн иргэдэд хүртээмжтэй үйлчлэн ажиллалаа.

### **Сант сум:**

Ургац тогтоолтын урьдчилсан балансын мэдээгээр: 2020 онд сумын хэмжээнд 2390 га-д улаанбуудай, 7га-д арвай, 210.5 га-д овъёос, 690 га-д рапс, 234.3 га-д ногоон тэжээл тариалснаас улаанбуудай тариалсан 477 га талбай ургац алдсан байна.1913 га талбайгаас хураалт хийж сумын дунджаар 14 цн ургац авч нийт 2272 тн улаан буудай, 210.5 га талбайгаас хураалт хийж га-аас 6 цн ургац авч 120 цн овъёос, 690 га-аас тосны ургамлын хураалт хийж 234.3 тн рапс, 85 тн ногоон тэжээл хураан авах ургацын урьдчилсан баланс гарсан байна.

Үр тарианы тариалалтын үеийн технологи, соёололтын байдал, цаг агаарын нөхцөл байдалтай холбогдон ургацын болц удааширсан тул “Монгол газар” ХХК, “Сант агро” ХХК, “Норбу агро” ХХК, “Баян хайрхан”, “Сант агро” ХХК-иудын үр тариа тариалсан нийт 1787 га талбай ногоон тэжээлд шилжээд байна.

09-р сарын байдлаар үр тариа үүнээс улаанбуудай 431 га-д ангилан хадалт хийж 8 га-д цайруулалт хийж 19 тн улаанбуудай хураан аваад байна. Төмс 189 га-гаас 2457 тн, байцаа 8.3 га-гаас 114 тн, лууван 86 га-гаас 1376 тн, шар манжин 21 га-гаас 321 тн, хүрэн манжин 4,3 га-гаас 42 тн, өргөст хэмх 9,3 га-гаас 31 тн, лооль 0.3 га-гаас 2.4 тн, сонгино 21,5 га-гаас 132 тн, хулуу 0.6 га-гаас 9.8 тн, тарвас 6,1 га-гаас 21 тн, броколли 0.02 га-гаас 0.6 тн, чинжүү 0.06 га-гаас 0.2 тн, нийт 346,4 га-гаас 4507 тн ургац аваад байна.

Хадлан тэжээл бэлтгэлийн ажил 08-р сараас эхлэн 3860 тн хадлан бэлтгээд байна. Сумын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зорилгоор бизнесийн хадлангийн зориулалтаар 600 га талбайд 11 иргэнтэй гэрээ хийж газар олгох ажлыг зохион байгууллаа. Энэ жил сумын нөөцөд нийт 1800 боодол буюу 36 тн өвс бэлтгэхээр төвлөвлөн ажиллаж байна.

Үр тарианы талбайд мал орсонтой холбоотой 2 аж ахуй нэгж, 1 иргэний гаргасан өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж “Тариалангийн талбайд мал амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохиролыг тооцох аргачлал”-ын дагуу хохирол тогтоох ажлыг хийсэн.

Цаг агаарын нөхцөл байдал, ургац хураалтын ажил удааширч байгаатай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А/100 тоот захирамжаар сумын төвд болон намаржаанд мал оруулах хугацааг 15 хоногоор сунган ажиллаж байна.

Газрын харилцааны чиглэлээр сумын Засаг даргын захирамж шийдвэрээр төр, төсвийн 4 байгууллагад 5.93 га, тариаланч 4 иргэнд 19.02 га газрыг эзэмшүүлж, 13 иргэнд 0.91 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон байна. Сэлэнгэ аймгийн “Налжирлха ХХК”, Дархан-Уул аймгийн “Гео Инженер сүрвэй” ХХК-тай тус тус хамтран гэр бүлийн хэрэгцээний 20, өвөлжөөний 13, төмс хүнсний ногооны 12, бусад зориулалтаар 7 нийт 52 нэгж талбарт кадастрын зураглал хийлгэж ажиллалаа.

2020 онд орон нутгийн татварын орлого 36974,0 мянган төгрөг төвлөрөхөөс 44312.9 мянган төгрөг /9-р сарын 21-ний байдлаар/ төвлөрч гүйцэтгэл 119.8 хувь буюу 7338.9 мянган төгрөгөөр давсан байна.

дд	Орлогын төрөл	Төл	Гүйц	Зөрүү
1	Үйл ажиллагааны орлого	60.81.5	11513.6	189.3
2	Бууны албан татвар	1500.0	936.0	62.4
3	Улсын тэмдэгтийн хураамж	1598.00	1654.1	103.5

4	Түгээмэл тархацтай ашигт малтмал	100.0	735.0	735.0
5	Хог хаягдлын хураамж	5567.5	2498.7	44.9
6	Газрын дуудлага худалдааны орлого	2000.0		
7	Газрын төлбөр		183.0	
8	Ойн нөөц ашигласны төлбөр	7510.2	12609.5	167.9
9	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	65.0	304.0	467.7
10	Байгалийн ургамал ашигласны төлбөр		1920.0	
11	Хүү торгуулийн орлого	5000.0	5245.3	104.9
12	Түрээсийн орлого	1000.0	829.5	83.0
13	Бусад орлого		2072.8	
	<b>Татварын орлогын дүн</b>	<b>30422.2</b>	<b>41198.4</b>	<b>135.4</b>
	<b>Аймгаас авах санхүүгийн дэмжлэг</b>	<b>482770.2</b>	<b>332855.3</b>	
	<b>Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн дэмжлэг</b>	<b>74363.5</b>	<b>48867.4</b>	
	<b>Нийт орлого</b>	<b>594107.7</b>	<b>426035.6</b>	

09-р сард орон нутгийн байгууллагад аймгаас авах санхүүгийн дэмжлэг 482770.2 мянган төгрөг авахаас 332855.3 мянган төгрөг авч, 513192.4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоос 363868.8 мянган төгрөгийг олгоод байна. ТЗШБ-ууд дээд шатны байгууллагаас авах санхүүгийн дэмжлэг 894864.7 мянган төгрөг авч зарцуулахаас 843263.4 мянган төгрөгийг авч зарцуулаад байна.

Тэтгэврийн даатгалын сангаас нийт 340 хүний 112555,5 мянган төгрөгийн тэтгэвэр тавьж олгосноос ХААН банкаар 150 хүний 50511,9 мянган төгрөг, Төрийн банкаар 190 хүний 62043,6 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус тавьж олгосон.

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- ЖА-р тэтгэмж 2 хүний 1143.5 мянган төгрөг
- ХЧТА-р тэтгэмж 1 хүний 28.3 мянган төгрөг тус тус олгосон.
- Оршуулгын тэтгэмж олгогдоогүй.

Ажилгүйдийн даатгалын сангаас:

- АЖ даатгалын сангаас 1 хүнд 251,2 мянган төгрөг олгосон.
- Эрүүл мэндийн даатгалын сандаа 8 хүний нийт 517,7 мянган төгрөг хуримтлуулсан.

2020-2021 оны хичээлийн жилд сумын хэмжээнд СӨБ-ын байгууллагад хамрагдах тойргийн 2-5 насны 185 хүүхэд байгаагаас 3-5 насны хүүхдүүдийг Дунд, Ахлах, Бэлтгэл А,Б гэсэн 4 бүлэгт нийт 94 хүүхдийг хүлээн авч сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2020 оны Засгийн газрын шийдвэрийн дагуу 2 настнуудыг цэцэрлэгт хамруулах болсонтой холбогдуулан бүлгийн зохион байгуултанд өөрчлөлт орж бага бүлгийн хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулсан. Бага бүлэг 32, дунд бүлэг 25, ахлах бүлэг 27, бэлтгэл бүлэг 33 хүүхэдтэй нийт 117 хүүхдийг СӨБ-д хамруулан ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургууль нь энэ хичээлийн жилд 12 бүлэгт 315 суралцагчидтай хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. “Үдийн хоол” хөтөлбөрт 1-5 дугаар ангийн 152 суралцагч хамрагдаж байна.

БСУГ-аас зохион байгуулсан Орхон бүсийн “Хичээл сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх” арга хэмжээний тухай сургалт сумын Ерөнхий боловсролын

сургууль дээр зохион байгуулагдаж Орхон бүсийн нийт 9 цэцэрлэгийн удирдах ажилтан, арга зүйч, эмч нийт 28 хүн хамрагдаж, сургалтын үеэр БСШУЯ-наас ЕБС болон СӨБ-ийн байгууллагуудын багш, арга зүйч нарт 3 ширхэгийг хүлээлгэн өгсөн.

Тус сумын Эрүүл мэндийн төвийн Чанарын багаас “Сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээ”-ний хэрэгжилтийг сайжруулах аян зохион байгуулж, аяны хүрээнд үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж угтах, лавлах үйлчилгээний хэсгийг тохижуулж ажиллалаа. Мөн сумын Эрүүл мэндийн төвд өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношлогооны ажил зохион байгуулагдаж Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Рашаант 5 сумдын нийт 273 багш, ажилчид хамрагдлаа. Багш ажилчдыг 18-34 нас, 35-45 нас, 46-64 нас, 65-аас дээш насны ангиллаар багц үзлэгт хамруулсан.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны А/40 тоот тушаалаар батлагдсан “Сувилагч солилцоо” аяны хүрээнд Орхон сумын Эрүүл мэндийн төвтэй хамтарч ахлах сувилагчийн туршлага солилцох ажиллагаа явагдлаа.

“Дэлхийн зөн ОУБ”-аас зарласан жижиг төслийн уралдаанд шалгарсан Соёлын төвийн “Монгол наадгай” төслийн тоглоом нийлүүлэлтийн ажил 09-р сард дуусч уг тоглоомуудыг тоолж, байгууллагын үндсэн хөрөнгөд орлогод авах ажил хийгдэж байна. Нийт 2765.0 төгрөгийн 25 ширхэг хөлөгт болон оньсон тоглоомууд тоологдсон.

### **Сүхбаатар сум:**

2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах сумын Засаг даргын захирамжийн дагуу сургууль, цэцэрлэгийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хяналт шалгалт хийж заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлага зохион байгуулах аймаг, сумын Засаг даргын захирамжийн хүрээнд 8 багийн Засаг дарга бэлтгэл ажил ханган, 18-25 насны 2-р зэргийн бэлтгэн үүрэгтэнд зарлан дуудах мэдэгдэх хуудас тараан ажиллаж байна.

Цэргийн дайчилгааны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад 1 иргэн хамруулж ажиллалаа.

“Үндэсний Техникийн Их сургууль”-ийн “Хууль зүйн салбар сургууль” Сэлэнгэ аймагт элсэгчид бүртгэж хичээл сургалтын үйл ажиллагааг явуулах болсонтой холбогдуулан иргэдэд цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Тус сард ирсэн бичиг 65, ирсэн өргөдөл 16, сумын Засаг даргын явуулсан бичиг 17, орлогч даргын явуулсан бичиг 19, Тамгын газрын дарга явуулсан бичиг 28, А захирамж 32, Б захирамж 2, А тушаал 1, Б тушаал 6 гарсан байна.

Сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй ажил арга хэмжээний мэдээ, мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх ил тодын самбарыг тухай бүр шинэчлэн ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн сарын аяныг сурталчлан ажиллаж, “Авлигаас урьдчилан сэргийлцгээе” зурагт хуудас, видео контентуудыг цаг тухай бүрт нь цахим хуудсаар иргэдэд хүргэн ажиллаж байна. Иргэний танхимд нийтдээ 6 сургалт, 2 удаагийн хурал зохион байгуулагдлаа.

Энэ хичээлийн жилд Сүхбаатар сумын ЕБС-ийн 1-р ангид 545 хүүхэд шинээр элсэн орж байна. СӨБ-д нийт хамрагдвал зохих хүүхдийн 95,4 хувь хамрагдаж байна. Яаралтай тулгамдаж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх хүрээнд Спортын сургуулийн дотуур байрны цагаан хэрэгслийг шинэчлэн шийдлээ.

Сумын хэмжээнд СӨБ-д хамрагдах 5 настны болон 1-р ангид шинээр элсэх хүүхдүүдийн судалгааг гарган хүн амын тоотой тулгалт хийж завсардалт үүсгэхгүй ажиллаж байна. Насан туршийн боловсролын төвийн дүйцсэн хөтөлбөрийн суралцагч 25 хүүхдийн “Үдийн цай” хөтөлбөрийн 2,0 сая төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж, 2021 оны зардлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг дарга болон БСУГ-т албан тоот хүргүүлж ажилласан

“Гэр бүлийг дэмжих туршилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд сумын хэмжээнд 44 өрхөд “Гэрээр айлчлах гэр бүлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн өрхүүдээс 28 гэр бүлд хүнсний эрхийн бичиг олгож, 8 гэр бүлийн 6 хүнийг ажлын байранд зуучлан, нийт 44 өрхийн иргэдийг түр ажлын байраар 2 удаа зуучилж, 6 хүнийг эрүүл мэндийн даатгалд хамруулан, 32 хүнд сургалт сурталчилгаа явуулах ажлыг хийж ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд гэрээр айлчилдаг 44 өрх, нийт хамрагдсан иргэд 109, үүнээс эрэгтэй 42 эмэгтэй 65 иргэн байна. Өрхөд буй нийт хүүхдийн тоо 143, ДЗОУБ-ын ХИТХ-т хамрагддаг хүүхэд 25, ХБ-тэй хүүхэд 7 байна. Эдгээр хүүхдүүдийг халамж, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучилж ажиллалаа. ГБХЗХГ-аас зохион байгуулсан 2 өдрийн сургалтад багийн 8 нийгмийн ажилтан хамруулсан.

Сэлэнгэ аймгийн “Дугуйтай Сэлэнгэ” спорт клуб нь олон нийтэд дугуйн спортоор хичээллэхийн ач холбогдлыг таниулах, Коронавирусын /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан аянд нэгдэж Засаг даргын нөөц хөрөнгөөс 150.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа. Мөн улсын, бүсийн болон “Дархан-88” дугуй сонирхогчдын анхдугаар наадамд оролцож амжилт гаргасан тус клубын тамирчдыг сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж урамшууллаа.

Ахмадын баярын өдрийг угтан “Хөдөлгөөн-Эрүүл мэнд-Урт наслалт” явган аялалыг зохион байгуулахаар ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Зохистой хөдөлгөөн-Эрүүл мэнд” явган аялалыг зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбарын хүний нөөцийг чадавхжуулах” 16 цагийн “СЕРТИФИКАТ”-тай сургалтад багийн нийгмийн ажилтнуудын хамруулж ажилласан.

Мал сүргийг урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулга боловсруулалтад нийт давхардсан тоогоор 61500 толгой мал амьтныг хамруулж, 74,9 мянган м2 талбайг халдваргүйжүүлэн төлөвлөгөөт ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сумын малчид мал бүхий иргэдийн мал сүрэгт 2020-2021 онд өвөлжиж, хаваржихад байгалийн хадлан 3786 тн, давс, хужир, шүү 202 тн хэрэгцээтэй байгаа ба хэрэгцээт хадланг Шаамар, Алтанбулаг, Зүүнбүрэн сумдын нутаг дэвсгэрээс бэлтгэж байна. Одоогийн байдлаар 1004 тн байгалийн хадлан, давс, хужир, шүү 20 тн бэлтгэсэн. 8 багийн малчин, мал бүхий 330 өрхийн нийт 23067 мянган толгой мал, үүнээс 2867 мянган толгой адуу, 5530 мянган толгой үхэр,

6930 мянган толгой хонь, 7740 мянган толгой ямаа, хилийн зурвас газарт нэг өрхийн 63 толгой мал өвөлжиж хаваржих урьдчилсан судалгаа гарган ажиллаж байна. Сумын хэмжээнд ургац хураалт 80 хувьтай явагдаж байна.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд сумын төмс, хүнсний ногоо тариалан эрхэлдэг 4 иргэн 18 төрлийн даршилсан ногоотой оролцож 6,5 сая төгрөгийн борлуулалттайгаар оролцлоо. JCI Монгол байгууллагын хэрэгжүүлж байгаа өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төсөлд аймгийн хэмжээний сонгон шалгаруулалтад сумаас төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг 2 өрх шалгарч Улаанбаатар хотод зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, бизнес аялал болон хэлэлцүүлэгт оролцлоо.

Стандарт хэмжил зүйн газар, МХГ-тай хамтран стандартын хэрэгжилт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг худалдаа, үйлчилгээний газруудад 2 удаа хийж ажиллалаа.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд ЕБС-ийн “Үдийн цай хөтөлбөр” болон сургууль, цэцэрлэгүүдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах хяналтыг хийж ажиллалаа.

Аймгийн 7036-1111 дугаарт ирсэн иргэн Д.Эрдэнэбулганы хог ангилан ялгах сав байрлуулах тухай гомдлыг байгаль, орчны Улсын байцаагчтай хамтран газар дээр очиж танилцан шийдвэрлэж ажиллалаа.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн сунгалт хийлгэх хүсэлт ирүүлсэн 5 аж ахуйн нэгжийн хүсэлтийг АЗДТГ-т уламжилсан.

Орон нутгийн хөрөнгөөр Орхон 6-р багт гэрэлтүүлэг тохижилтийн ажил, Аймгийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн Партизаны талбай Цэнгэлдэх хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажил, 1-р сургуулийн спорт заалны засварын ажлуудын гүйцэтгэл дуусч, хүлээн авч байнгын ашиглалтад оруулаад байна.

2019 онд ОНХСХ-р хийгдэх ажлуудыг баг тус бүрээр эрэмбэлэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулсан ажиллалаа.

16 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр:

- Өглөгийн хэмжээ 13,330,859.67 төгрөг байснаас 25,487,291.34 буюу 47,7 хувийн өсөлттэй,
- Авлагын хэмжээ 81,283,878.97 төгрөг байснаас 43,133,422.67 буюу 53 хувийн бууралттай байна.

### **Түшиг сум:**

Хичээлийн шинэ жилийн үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг сахиулан ажиллаж, хүүхдүүдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж, бэлтгэл ажлын хүрээнд ариутгал халдваргүйтгэлийг “Мөнх Ариун Сэлэнгэ” ХХК-иар гүйцэтгүүлж ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 5 бүлэгт нийт 146 суралцагч, Ерөнхий боловсролын байгууллагад 312 сурагч суралцаж байна.

Сумын Засаг даргын захирамжаар “Өвөлжилтийн бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувьтай байна. Малчин, мал бүхий иргэдийн хадлангийн газрын хуваарилалтыг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, хадлан тэжээл бэлтгэлийн ажил 70 хувьтай явагдаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дараах ажил арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:

- Эрүүл мэндийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг “Мед буян” ХХК 25,0 сая төгрөг
- Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн ажлыг “БУММ” ХХК -/13,8 сая төг/
- Цэцэрлэгийн тавилга тохижилтын ажлыг “Дорнын хэлхээ” ХХК - /9,1 сая төг/ гүйцэтгэж, байнгын ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна.

Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас 35 албан бичиг ирсэн бөгөөд хугацаатай 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

Төрийн байгууллагын портал “Хур” системээс 11 иргэнд холбогдох лавлагааг гаргаж үйлчиллээ.

Сумын Засаг даргын 2020 оны А/71 тоот захирамжаар “Ургац тогтоолт явуулах ажлын хэсэг”-ийг байгуулж нийт 7 аж ахуйн нэгж, 3 иргэний 9563 га талбайн ургацыг тогтоож, нэгж га талбайгаас 13,9 цн-ээр тогтлоо.

09-р сарын байдлаар нийт 896 га талбайгаас 812,8 тн ургац хураан авсан. Улаанбуудай 796 га талбайгаас 772,8 тн буюу нэгж га талбайгаас 9,7 цн, рапс 100 га талбайгаас 40 тн ургац хураан авч нэгж га талбайгаас 4 цн, төмс 1 талбайгаас 14 тн хураан авсан бол хүнсний ногоо 6,9 га талбайгаас 60,9 тн хураан авсан. Байцаа 0,5 га-аас 4,5тн, сонгино 1,2 га-аас 9,6 тн, сармис 2,2 га-аас 19,8 тн, өргөст хэмх 3 га-аас 27 тн-ийг тус тус хураасан дүнтэй байна.

Тайлант сард эмнэлэгт 15 хүнийг хэвтэн эмчлүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 3 эхийг шилжүүлэн төрүүлсэн. Жирэмсний хяналтанд 3 эхийг шинээр авч, эхний 3 сартай эхийн хяналт 100 хувь бөгөөд одоогоор хяналтанд 21 эх байна. Осол гэмтлийн өвчлөл 3 бүртгэгдсэнээс дээд шатны байгууллагад 2 хүнийг хүргэж, алсын 5, ойрын 43 дуудлагад үйлчилсэн.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын үзлэг шинжилгээнд боловсролын салбарын нийт 61 багш, ажилчид хамрагдлаа.

“Соёлын цаг” нөлөөллийн аяны нээлтийн арга хэмжээний хүрээнд 8 ажлыг төлөвлөж, ЕБС-ийн сурагчдын дунд “Хязгааргүй ном сэтгэлгээний эрх чөлөө” уриатай номын баяр арга хэмжээг зохион байгуулж, нүүдлийн номын сан, явуулын музейгээр үйлчиллээ.

### **Хушаат сум:**

Төрийн үйлчилгээний нэгдсэн портал системийг суманд нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 54 нэр төрлийн лавлагаа үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Нийтдээ 138 үйлчилгээний хүсэлт илгээснээс 122 үйлчилгээг шийдвэрлэн олгож, лавлагаа үйлчилгээг давхардсан тоогоор 122 иргэнд үзүүллээ.

Сумын сонгуулийн хорооноос Аймаг, нийслэл сум, дүүргийн сонгуулийн тухай хуулиар сонгуулийн хороо, хэсгийн хорооны 23 төрийн албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

Энэ сард талх 0,9 тн, блок 6000 ширхэг үйлдвэрлэсэн. Сумын хэмжээнд төмс хүнсний ногоо 255,392 тн хураан авсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 25 аж ахуйн нэгжийн 204106.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 127 хүний 25166.6 мянган төгрөгийн хураамжийг төвлөрүүлж ажиллалаа. Нийгмийн даатгал

болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн заалтуудаар 595 хүнд зөвлөгөө өгч нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд малчид, ХХЭ, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамрагдах талаар гарын авлагыг 215 хүнд тарааж ажилласан.

Нийт халамжийн тэтгэвэр тэтгэмжинд 122 иргэнд 14878000 сая төгрөгийг олголоо. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ажил зуучлалд 2 иргэн бүртгэж LIMS программд шивж ажиллалаа.

Гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлийн утас 108 утсанд ирсэн дуудлагын дагуу 3 айлд нөхцөл байдал, аюулгүйн зэргийн үнэлгээ хийж, гэр бүлийн хүчирхийллийн 3 кэйст хувийн хэрэг нээн нөхцөл байдал, аюулгүй зэргийн үнэлгээ хийн холбогдох материалуудыг бүрдүүлж, ар гэрийн гишүүдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.

БШУС-ын А/17тоот “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх, бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тушаалын дагуу багш нар хичээл сургалтын үйл ажиллагаанд бэлтгэн, төлөвлөгөө гарган, эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө, зөвлөмж чиглэл хүргүүлж, хүүхэд хоорондын зай барих тэмдэг тэмдэглэгээг хийж ажиллаж байна.

**Хамран сургалт:**

№	Бүлгүүд	Сумын хэмжээний хүүхдүүд				Үүнээс цэцэрлэгт	Хувилбарт сургалт	Шилжиж явсан	Хөдөө
		2 нас	3 нас	4 нас	5 нас				
1	Бэлтгэл				60	40		17	4
2	Ахлах			13		20	13	16	
3	Дунд		39			17		3	19
4	Бага	50				20		3	27
5	Бүгд					97	13	39	50
	199								

Зохиолч Х.Дуламсүрэнтэй Хушаат сумын цахим номын сангийн Facebook хуудсаар уулзалт ярилцлагыг нийт Хушаат сумын ард иргэдийн дунд зохион байгууллаа.

“Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх хууль”-ийн дагуу 7 хоногийн аян өрнүүлж, эцэг, эх, иргэдэд “Эцэг, эх та өөрөө хүчирхийлэгч биш биз” сэдэвт сургалтыг зохион байгуулж, гарын авлага зөвлөмжийг тарааж ажиллалаа.

Сурагчдын дунд “Хүсээгүй харилцаа хүүхэд бидний нүдээр” гар зураг, эссэ бичлэгийн уралдааныг зарлаж, үзэсгэлэн гаргаж, хүүхэд багачуудын дуу хоолойг томчуудад хүргэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

“Хоггүй сум болцооё” аяны хүрээнд цахим орчинд хоггүй сум болцооё уриалгыг гаргаж улмаар сургуулийн ойр орчим болон сумын хогийн цэгийн хогийг цэвэрлэх ажлыг сургуулийн НУЗАН-ийн хамт олонтой хамтран зохион байгуулж эцэг эх, сумын ард иргэдтэй хамтарч ажиллалаа.

Эрүүл мэндийн төвийн үзлэг шинжилгээнд нийт 95 хүн хамрагдсан байна.

- Амбулаторийн үзлэг 80
- Урьдчилан сэргийлэх үзлэг 15

- Түргэн тусламжийн дуудлага 35
- Алсын 8 дуудлагат ажиллалаа.

### **Хүдэр сум:**

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж, цаг үеийн холбогдолтой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

1. Сум орон нутгийн өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах тухай
2. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, явц, үр дүнгийн талаар болон сэтгүүлийн эх бэлтгэл
3. Хадлангийн ажил болон сумын фондний өвс нөөцлөх тухай
4. Сумын 2020 оны Төсөвт тодотгол хийх тухай
5. Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар бэлтгэгдэх хуш модны самрын тухай дээрх 5 асуудлыг хэлэлцэж холбогдох албан хаагчдад үүрэг даалгавар өгсөн.

Хадлан өвс бэлтгэлийн явцын талаар иргэд малчидтай уулзаж, бизнесийн зориулалтаар 5 ААН, 38 иргэнд нийт 3200 га газрыг олгоод байна. Сумын өвсний фонд бэлтгэх ажлыг ХАА-н тасгын дарга, газрын даамал нар хариуцан бизнесийн зориулалтаар хадлан хадах ААН-ээс 100 боодол, иргэнээс 50 боодол, өвс авахаар гэрээнд тусган ажиллаж байна.

Тухайн сард сумын Засаг даргын захирамж 17 гарч, үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 16, боловсон хүчний чиглэлээр 1, Засаг даргын 31 тоот гарсан байна.

Орон нутгийн орлого 116,933,8 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас 188,264,1 сая төгрөг орсон байна. Орон нутгийн төсвийн төвлөрсөн байгууллагуудад 36,177,4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр төсөвт байгууллагуудад 79,188,8 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Нийт сарын дүнгээр 41773, төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэл 537608,1 мян.төгрөг төвлөрсөн байна.

БШУ-ны 2020 оны А/17 тушаалын 1-р хавсралтаар 15 багш ажилтанд сургалт зохион байгуулж, 7 бүлэгт 181 хүүхэд хүлээн авахаар багш туслах багш нарыг бүлгүүдэд хувиарлаж, 3 гарцаар багш ажилтаны ажил үүргийн хуваарь хүний нөөцийн зохион байгуулалт хийж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль 2020-2021 оны хичээлийн жилд удирдах ажилтан 4, багш 32, үйлчилгээний ажилтан 19, 22 бүлэгт 604 сурагчтай сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

МУЗГ-ын санаачлагаар Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас хамтран зохион байгуулж буй "Соёлын цаг" аяны хүрээнд төв талбайд урлагийн тоглолт иргэдэд үзүүлж, 34 иргэн, Дархан төмөрлөгийн ажилчдад соёл урлагийн арга хэмжээнд 79 иргэн, "Соёлын цаг" аяны хүрээнд "Эх хэл соёлын дархлаа" арга хэмжээг хөдөө тариаланчдын дунд өрнүүлж ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нийт 18 иргэнд үзүүлж, үүнээс 2 даатгуулагчид эрүүл мэндийн түр хуудас олгож, 8 даатгуулагчийн 326500 төгрөгийн шимтгэлийг эрүүл мэндийн даатгалын санд, 10 даатгуулагч улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлсөн байна. Сайн дурын даатгалд 2 даатгуулагч шинээр даатгуулсан 1 ажилгүй, 1 малчин иргэн

хамрагдсан. Нийт 9 даатгуулагчийн 388.800 төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн ажиллалаа.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд нийт 7 цэгт ургамлын дээж авч, хэмжилт хийн боловсруулалтыг хийж ажиллалаа. Газар өмчлөх эрх үүссэн 7 иргэний хүсэлтийг хүлээн авч улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай материалыг бүрдүүлэн иргэдэд хүлээлгэн өгч ажилласан.

Сэлэнгэ аймгийн МХГ-ын даргын 18/02 тоот “Хяналт шалгалт хийх тухай” байнгын удирдамжийн хүрээнд холбогдох албан хаагчидтай хамтран уул уурхайн чиглэлээр хяналт шалгалтыг “Хүдэр гол”-ын эхэнд 2 удаа хийж гүйцэтгэн нөхөн сэргээлт, хөдөлмөр аюулгүй байдал, зөрчил дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

2020 онд ойгоос мод бэлтгэх хуваарьт орсон аж ахуй нэгж, нөхөрлөлүүдийн ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавин ажиллаж байна. Байгалийн дагалдат баялаг болох Хуш модны самар түүж бэлтгэх БОАЖС-ын тушаал, сумын ИТХ-ын тогтоолын дагуу 24 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, хяналт тавин ажиллаж байна.

“Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ий хүсэлтийн дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах үйлдвэрийн “Уурхайн тэлэлтэнд өртөж буй талбайн ойн нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тооцох хээрийн хэмжилт”-ийн ажлыг хийж ажиллалаа.

БОАЖЯ, “Ойн судалгаа хөгжлийн төв”-ийн 2020 оны 1/11 албан тоотыг үндэслэн “Тарс” ХХК-ий эзэмшлийн ойн санд 2015 онд хүчтэй салхи, шуурганд өртөж нэлэхүйдээ хатаж, хугарч гэмтсэн, 2017 оны ойн түймэр болон их цасанд дарагдсан зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас цаашид амьдрах чадваргүй болж модлогийн чанар муудсан 17 га талбайн ойн цэвэрлэгээг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх захирамжийг үндэслэн байгаль хамгаалагч, ойн ангийн инженертэй газар дээр нь хяналт шалгалт хийж ажиллалаа.

### **Цагааннуур сум:**

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан уламжлал болгон зохион байгуулагддаг алслагдсан багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх зорилготой “Төрийн үйлчилгээг–Иргэн бүрт” өдөрлөгийг 2020 Тийрэг 3 дугаар багт халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулсан.

Сумын төвийн 1.3 км хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн 2.53 км хатуу хучилттай зам тавихаар зураг төсөв хийлгэсний дагуу өнгөрсөн жил тавигдсан 200 м хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн энэ жил 380м зам тавих, сумын төв доторх сайжруулсан шороон замыг тэгшлэх, сумын нэгдсэн хогийн цэгийг түрж, цэвэрлэх ажлууд эхлээд байна.

2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Хүндэтгэлийн хуралдаан” зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/255 тоот захирамжийн дагуу 2020 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлага зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, 18-26 насны хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудад

зарлан дуудах хуудас гардуулах ажлыг багийн засаг дарга нартай хамтран зохион байгуулж байна.

2020 оны 08 дугаар сард гал түймрийн улмаас орон гэргүй болсон 2 дугаар багийн иргэн Б.Оюунболдын /ам бүл 7/ гэр бүлд туслах “Дэм дэмэндээ” аяныг зохион байгуулж, аяны хүрээнд Тийрэг 3 дугаар багт гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар олгож сумын иргэдийн хандив тусламжаар хашаа, иж бүрэн тавилгатай шинэ гэрийн хамтаар хүлээлгэн өгч ажиллалаа.

“Ураг удмын алтан хэлхээ” сэдэвт угийн бичгийн сургалтад сумын угийн бичиг хөтөлдөг иргэдийн төлөөлөл, сумын номын санч, нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамрагдаж, үзэсгэлэнд оролцлоо.

Тэтгэврийн даатгалын сангаас:

- 437 өндөр настанд -161 029.8 мян төгрөг
- 49 тэжээгчээ алдсан иргэнд -16 320,0 мян төгрөг
- 230 тахир дутуу иргэнд - 73 926,1 мянган төгрөг
- 4 цэргийн өндөр настанд -2508.0 мян төгрөг

ҮОМШӨ Даатгалын сангаас:

- 4 иргэнд 1417.6 мян төгрөг

Тэтгэмжийн даатгалын сангаас:

- ХЧТАлдсан 14 иргэнд -1 270,0 мян/төг
- ЖАмаржсан 7 эхэд-9 924,1 мян/төг
- Оршуулгын тэтгэмж 1 даатгуулагчид -1 000,0 мян/ төг

Ажилгүйдлийн даатгалын сангаас:

- 1 даатгуулагч -1 205,0 мян төгрөгийн тус тус олгоод байна.

Сумын татварын орлого 09-р сард 2352.9 мян/төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 09-р сарын 23-ны өдрийн байдлаар 13138.1 мян/төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 558.3 хувийн биелэлттэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 09-р сарын санхүүжилт 100 хувь олгогдсон байна. Аймгаас ирэх 09-р сарын дэмжлэг, санхүүжилт, орон нутгийн байгууллагуудын санхүүжилт олгогдсон байна. ОНХС-ийн санхүүжилт 99225,7 мян/төгрөгийн санхүүжилт ирж 14072.0 мян/төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шилэн дансны нэгдсэн сайтад хуулийн хугацаанд байршуулан төсөвт байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг үнэн зөв бодитой тогтоосон хугацаанд тогтмол мэдээллүүлэн хяналт тавин ажиллаж байна.

Төрийн сангийн дансаар 176.058.427 мян.төгрөгийн 131 ширхэг гүйлгээ хийгдсэн байна

Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх эргүүл, шалгалтыг Атар, Шүрэнгийн голын чиглэлд 24 цагийн хөдөлгөөнт эргүүл гарган ажиллаж байна.

Байгаль хамгаалагч, багийн Засаг даргын хамт “Нуурын ар”, “Оргихын адаг”, “Чандагатай”, “Цацан”, “Шүрэнгийн гол”-ын чиглэлд сумын Засаг даргын А/93 тоот захирамжийн дагуу мэдэгдлийг айл өрхүүдэд хүргүүлж 40 гаруй өрх, 5 аж ахуй нэгжийн 76 иргэнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргүүлж ажиллалаа.

ХААДС-аас зээл авч байгаа 1 аж ахуйн нэгж, 1 иргэний газрын гэрчилгээг барьцаа бүртгэл хийж 1 иргэний 1 нэгж талбарыг чөлөөлсөн.

Ургац хураалтын явцын мэдээ:

№	Улаанбуудай				
	Ангилсан талбай/га	Хураасан талбай/га	Нэгжийн ургац/цн	Хураасан ургац/тн	Хувь
1	3690	2306	17.9	4136	9.38
<b>Рапс</b>					
2	6168	300	6	180	4.86

Сумын Засаг даргын 2020 оны А/69 тоот захирамжийн дагуу Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд тугал 4200, хурга 23000, ишиг 15400 толгой мал, амьтныг хамруулж 100 хувьтай гүйцэтгээд байна.

- Туулгалтад нохой 1120, үхэр 10941, адуу 3435, бог 111173, гахай 1131,
- Угаалгад үхэр 12165, бог 218284 толгой мал шүршиж, 1500 толгой бог
- Боловсруулалтад бог 43693, үхэр 25515, адуу 900, нохой 150, гахай 1325
- Үхрийн гуурын боловсруулалтад 15860 толгой мал, амьтныг тус тус хамруулж, гүйцэтгэл 46.1 хувьтай байна.

09-р сард адуу 6, үхэр 42, хонь 636, ямаа 240, мах 2172 кг, сүү 1100 литр, аарц 100 кг, ааруул 41 кг, шар тос 6кг-т тус тус цахим гэрчилгээ бичигдсэн.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа 4 мал эмнэлгийн нэгжүүд нийт 349 хашааны 107300 м<sup>2</sup> талбайг ариутгаж халдваргүйжүүлж ажиллалаа.

#### **Шаамар сум:**

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Засаг даргын 2020 оны А/74 дугаартай “2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” удирдлага зохион байгуулах хангах, хүлээн авах, сумын хэмжээнд ургацыг урьдчилан тогтоолт явуулах, ургац хураалтыг чанартай зохион байгуулахад хяналт тавих, төр төсвийн байгууллага, айл өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавих, мал аж ахуйн урьдчилан сэргийлэх, хадлан тэжээл бэлтгүүлэх, хяналт тавих зэрэг ажлуудыг хийж зохион байгуулж тус бүр дээр ажлын хэсэг томилон ажиллуулж байна.

Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолыг үндэслэн ёс зүйн хорооны зөвлөлийн гишүүдээ шинээр бүрдүүлэн ажилласан. Мөн Авилгатай Тэмцэх газрын 2020 оны 02/796 тоот албан тоотын дагуу авилгын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж, иргэдэд цахимаар болон гарын авлага бэлтгэн мэдээлэл хүргэж ажилласан.

Гэр бүл хүүхэд залуучуудын газраас зохион байгуулсан түр хамгаалах байранд ажиллаж буй албан хаагчдад зориулсан 2 хоногийн сургалтанд холбогдох албан хаагчдыг хамруулан ажиллалаа. Мөн “Ураг удмын хэлхээ” угийн бичгийн хэлэлцүүлэгт оролцсон.

Сумын төв хогийн цэгийн хог хаях талбайд 3 га газрын хогийг түрж, далан болгон цэвэрлэх ажлыг зохион байгууллаа. ЗДТГ-ын арын 250 метр урттай сайжруулсан шороон замыг засах ажилд хяналт тавьж ажилласан. “Ойн тухай хууль”, “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”, “Амьтны тухай хууль” болон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 18/02 тоот байнгын хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд хууль бусаар загас агнах барих, ой

хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж, Тужийн нарс, Орхон голын салаа, тохой болон орон нутгийн төв замаар зорчиж буй 18 тээврийн хэрэгслийг шалгахад зөрчил илрээгүй. Тухайн тээврийн хэрэгсэлд зорчиж байсан 26 иргэнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ухуулга таниулга хийж ажилласан. Жимс жимсгэнэ түүж яваа болон хадлан тэжээл бэлтгэж буй иргэдэд ой хээрийн түймэр урьдчилан сэргийлэх, хог хаягдал хаяхгүй байх талаар мөн тэмээн хүзүү тужийн нарс орчмоор баавгай үзэгдэх болсон тул сонор сэрэмжтэй байхыг сануулж анхааруулж ажилласан. Хадлан тэжээл бэлтгэж буй иргэдийн хооронд гарсан хадлангийн 5 маргааныг арилгаж, газрын хэмжээ заагийг зааж өгсөн. Төвийн ухаалаг худаг, мөн сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийг хэрэглээний цэвэр усаар хангаж байдаг худаг, 2 дугаар багийн цэцэрлэгийн худаг зэрэг 3 гүний худгийн уснаас дээж авч аймгийн МХГ-ын дэргэдэх итгэмжлэгдсэн лаборторид хүргүүлсэн.

2020 оны Орон нутгийн сонгуультай холбогдуулан аймаг, сумын ИТХ-д нэр дэвшиж байгаа 42 нэр дэвшигчдийн өрийг барагдуулан ажилласан.

Дараах татварын төрлөөр орлогыг төвлөрүүлэн ажилласан.

- Улсын төвлөрсөн төсөвт-5,107,703.4 төгрөг
- Аймгийн төвлөрсөн төсөвт-1,981,961 төгрөг
- Сумын төсвийн орлого-1,005,756.4 төгрөг

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 42 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцэн, шийдвэрлэж дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид байнгын асаргаа 1, цалинтай ээж 12, жирэмсэн эх 1, ахмадын амралт, сувилалд 5, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 1, тэжээгчээ алдсаны тэтгэмж 2, халамжийн тэтгэвэр 2, түлээний хөнгөлөлтөд 14, шинэ төрсөн хүүхдийн мөнгөн тэтгэмжид 2 иргэнийг тус тус хамруулж ажиллалаа.

Халамжийн үйлчилгээ цахимжиж байгаатай холбогдуулан 6 төрлийн халамж авдаг харъяа хүмүүсийн холболт, тулгалт, олголтыг хийн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангаар 23 ажил олгогч нийгмийн даатгалын санд шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 5 иргэнийг хамруулж, нийт 88 даатгуулагчийн шимтгэлийг төлүүлж, орлогын төлөвлөгөө 09-р сард 28750.55 сая төгрөг төвлөрүүлж ажиллахаас 23-ны байдлаар 20731,0 сая төгрөг төвлөрсөн байна.

Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын 2018 оны А/105 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ”-г сумын “Дэлгэрхаан”, “Охиндий” багийн хүнсний ногоо тариалагч иргэдийн 2020 оны ургац хураалтаас Улаанбаатар, Дархан, эрдэнэт зэрэг хотуудад борлуулах төмс, хүний ногоонд мэдрэхүйн үзлэгийн дүн шилжилгээ хийж нийт 400 тн хүнсний ногоо 35 гаруй тээврийн хэрэгсэлд гэргчилгээ гарган өгч ажиллалаа. Аймгийн МХГ-ын 01/560 “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан тоотын дагуу суманд үйл ажиллагаа эрхэлж буй 1 сүлжээ дэлгүүр, 9 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийж, “Ган зам” хүнсний дэлгүүрээс хугацаа дууссан, худалдахыг хориглосон “Дауао” жимсний хийжүүлсэн 18 ширхэг ундааг хураан авч ажиллалаа. Тарьмал ургамлын талбайд мал тэжээвэр амьтан орсон тухай дуудлага ногоочдоос 3 удаа авч, ирсэн өргөдөл, гомдлын дагуу тухай бүр сумын хохирол

тогтоох комисс ажиллаж, 2 дуудлагын хохирлыг тогтоон, хохирол учруулсан иргэнд иргэн, хохирсон актыг хүлээлгэн өгч ажилласан.

“Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногооны аж ахуй эрхлэгч 19 иргэнийг оролцууллаа.

Тайлант оны 09 дүгээр сарын байдлаар сумын Засаг даргын А захирамж 20, Б захирамж 3, сумын Засаг даргын Тамгын газрын даргын Б тушаал 4, Засаг дарга, Тамгын газрын даргаас явсан бичиг 37, аймгийн ЗДТГ-аас албан тоот ирснээс 8 хариутай бичигт хяналт тавьж, хариуг хүргүүлэн ажилласан.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫНДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА